



ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН 2019-2021





ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН

МЭДЭГДЭЛ

Энэхүү тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3
Товчилсон үгийн жагсаалт	5
Зураг, хүснэгтийн жагсаалт	7
МЭДЭГДЭЛ	8
СУДАЛГААНЫ БАГ	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРСГАЛ ЧИГЛЭЛ	9
1.1. Гадаад улсад үйлдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэл	11
1.2. Гадаад улсын иргэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болох эрсдэл	13
1.3. Дотоод дахь ХХГХ-ийн урсгал чиглэл	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО	19
2.1. Урьдчилан сэргийлэх	20
2.1.1. Төрийн байгууллагууд	25
2.1.2. Олон улсын байгууллагууд	32
2.1.3. Төрийн бус байгууллагууд	36
2.2. Хохирогч хамгаалал	39
2.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	45
2.4. Хамтын ажиллагаа	52
2.4.1. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа	53
2.4.2. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа	57
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	59
Хавсралт 1. Ашигласан баримт бичгийн жагсаалт:	66



ТАНИЛЦУУЛГА

2020 оны 04 дүгээр сард Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент болон Монгол Улсын Засгийн газар хооронд “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” гэрээг байгуулсан. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих энэхүү түншлэлийн зорилго нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй арга барилыг нэвтрүүлэх, гэмт этгээдүүдэд зохих ял шийтгэл оногдуулж, Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-тэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж чадавхыг бэхжүүлэхэд оршино. Уг төслийн үйл ажиллагааг Дэлхийн зөн Монгол Олонулсын байгууллага (ДЗМОУБ) болон Азийн сан хамтран хэрэгжүүлж байна¹. Төслийн үйл ажиллагааг ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба болон ХНХЯ ерөнхий удирдлагаар ханган ажиллаж байна.

Төслийн хүрээнд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох явцыг сайжруулах, үйл ажиллагааг уялдуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах тогтолцоог бэхжүүлэх зорилгоор дата мэдээлэлд суурилсан **“ХХГХ-тэй тэмцэх нөхцөл байдлын тайлан”**-г жил бүр боловсруулж, холбогдох талуудад түгээхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд “ХХГХ-тэй тэмцэх нөхцөл байдлын тайлан”-ийн анхны хувилбарыг Азийн сангийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн 2022 оны 07 дугаар сараас 10 сарын хооронд гүйцэтгэлээ. Цаашид уг тайланг Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл (*цаашид Дэд зөвлөл*)-ийн дор байгуулагдсан Салбар дундын хамтарсан баг² (СДХБ)-аас жил тутам боловсруулж, холбогдох талуудыг тогтмол, нэгдсэн мэдээллээр хангаж ажиллахаар төлөвлөж байна.

Энэхүү нөхцөл байдлын тайланг тоон болон чанарын судалгааны аргад үндэслэн боловсруулсан. Тоон судалгааны хүрээнд сүүлийн гурван жилийн хугацаанд салбарын холбогдох байгууллагуудаас гаргасан албан ёсны статистик мэдээллүүдийг ашигласан бол чанарын судалгааны хүрээнд олон улсын, үндэсний эрх зүйн баримт бичгүүд, сүүлийн гурван жилийн хугацаанд буюу 2019-2021 оны хооронд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төр, төрийн бус (ТББ) болон олон улсын байгууллагуудаас гаргасан нийт 20 гаруй судалгааны тайлангуудад баримт бичгийн шинжилгээ хийж боловсрууллаа. (*Ашигласан баримт бичгүүдтэй* Хавсралт 1.-ээс *танилцана уу*). Түүнчлэн “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” төслийн хүрээнд тус оны 07 дугаар сард зохион байгуулагдсан “ХХГХ-ийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл хэлэлцүүлэг”-ийн үеэр салбарын голлох оролцогч талуудын өгсөн мэдээлэл, санал, зөвлөмжүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийж уг тайланд тусгасан болно.


Тус тайланг боловсруулахад 2019-2021 оны тоо статистик, хийгдсэн судалгааны үр дүнгүүдэд дүн шинжилгээ хийж боловсруулсан тул тус тайланд дурдагдсан үр дүнгүүд нь дээрх хугацааны нөхцөл байдлыг илэрхийлнэ.

¹ Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, Азийн сан

² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/17 дугаар тушаалаар АНУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулав.

Дээрх аргуудаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажлын даалгаварт тусгагдсаны дагуу ХХГХ-тэй тэмцэх чиглэлд олон улсад нийтлэг ашиглагддаг арга зүйн хүрээ болох 4P³-ийн хүрээнд “ХХГХ-тэй тэмцэх нөхцөл байдлын тайлан”-г боловсруулан уншигч танд хүргэж байна.

Зураг 1. Судалгааны арга зүй:



³ Урьдчилан сэргийлэх – Prevention; Хохирогч хамгаалал – Protection; Хэрэг хянан шийдвэрлэх – Prosecution; Хамтын ажиллагаа – Partnership



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЛГБТ	Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендэр
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УИХ	Улсын их хурал

УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХИС	Хүүхдийг ивээх сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭСЯ	Элчин сайдын яам
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭЦА	Эрүүгийн цагдаагийн алба



ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Судалгааны арга зүй:	4
Зураг 2.	ХХГХ-тэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл заалтаар	10
Зураг 3.	Бэлгийн мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд	11
Зураг 4.	Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд	12
Зураг 5.	Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд, хөдөлмөр эрхлэх визтэй иргэдийн ажиллаж буй салбар	14
Зураг 6.	ХХГХ үйлдэгдэх эрсдэл бүхий байршлууд, эмзэг хүчин зүйлээр	17
Зураг 7.	Хүчирхийллийг зогсоход эх дэлхийгээрээ нэгдье аян, ДЗМОУБ	34
Зураг 8.	Мөрөөдлийн шүхэр аян, ОУШХБ	35
Зураг 9.	Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь сургалт"-ыг ГХУСА33 болон НҮБ-ын Хүүхдийн сан 2021 онд хамтран зохион байгуулав.	35
Зураг 10.	"Чи ганцаараа биш" нөлөөллийн ажил	36
Зураг 11.	Монгол Улсад хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй механизмын зураглал	40
Зураг 12.	ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээний төрөл	42
Зураг 13.	2020, 2021 онд бүртгэгдсэн зарим гэмт хэрэг хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүний тоон харьцуулалт	46
Зураг 14.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн инфо-график	48
Зураг 15.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг хангах бүтцүүд	53
Зураг 16.	ХХГХ-ийн бүртгэл, мэдээллийн урсгал	55
Хүснэгт 1.	Гадаад улсаас эх оронд нь эгүүлэн авчирсан хохирогчдын тоо	12
Хүснэгт 2.	Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд, улс орноор, нийтлэг ажлын байраар	15
Хүснэгт 3.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн сургалтуудын тойм	20
Хүснэгт 4.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн судалгааны ажлуудын тойм	22
Хүснэгт 5.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах ажлуудын тойм	22
Хүснэгт 6.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн үндэсний аяны ажлуудын тойм	23
Хүснэгт 7.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн мэдээлэл, сурталчилгааны ажлуудын тойм	24
Хүснэгт 8.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн голлох ажлуудын тойм	33
Хүснэгт 9.	ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн ажлуудын чиглэл	37
Хүснэгт 10.	Хохирогчийн талаарх хуулийн тодорхойлолтууд	41
Хүснэгт 11.	Хамтын ажиллагааны хүрээнд байгууллагуудад тулгарч буй бэрхшээл /матриц/	58



МЭДЭГДЭЛ

Энэхүү “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нөхцөл байдлын тайлан”-г 2019-2021 оны хооронд хийгдсэн судалгааны тайлангуудад үндэслэсэн боловсруулсан тул тайланд тусгагдсан үр дүнгүүд нь баримт бичгийн судалгааны нэгтгэсэн үр дүнг илэрхийлнэ.

СУДАЛГААНЫ БАГ

Гүнсэнчоймболын Амаржаргал	Судалгааны багийн зөвлөх, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын арга зүйч, магистр, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Нарангийн Болдмаа	Судалгааны багийн зөвлөх, МУИС-ийн ХҮС-ийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Жаргалсайханы Жавхлан	Төслийн зохицуулагч, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач

Энэхүү тайланг Азийн сангийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэлээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРСГАЛ ЧИГЛЭЛ



1.1. Гадаад улсад үйлдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэл

1.2. Гадаад улсын иргэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болох эрсдэл


1.3. Дотоод дахь ХХГХ-ийн урсгал чиглэл

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРСГАЛ ЧИГЛЭЛ

Монгол Улсад 2019-2021 оны хооронд хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ) болон түүнтэй төстэй 65 хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах зүйл ангиар 41, 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг 18, 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх 4, 15.3 дугаар зүйл Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах 2 гэмт хэрэг тус тус бүртгэгджээ.

Зураг 2. ХХГХ-тэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл заалтаар



Эх сурвалж: Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан, Азийн сан, ХТЭТ, 2022

ХХГХ-ийг тодорхойлох нэг гол шинж нь хүнийг мөлжих буюу ашиг олох зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах буюу хүлээн авах үйлдлийн аль нэг нь хийгдсэн байх ёстой. Гэхдээ ХХГХ-ийг заавал нэг байршлаас нөгөөд шилжүүлэх, өөр орон нутгаас өөр орон нутаг руу, нэг улсаас өөр улс руу тээвэрлэж байж үйлдэгддэг гэж үзэхгүй бөгөөд нэг нутаг дэвсгэрт зорчих эрхийг хязгаарлаж болон хязгаарлахгүйгээр үйлдэгддэг онцлогтой.

Энэ бүлэгт дурдагдаж буй мэдээллүүд нь 2019-2021 оны хугацааны төлөв байдлыг илүү илтгэх ба энэ хугацаанд дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлын тархалт дэгдсэнтэй холбоотой бүх нийтийн хөл хорио, хориг, хилийн хязгаарлалтууд авсан нийгэм цаг үеийн нөхцөл байдлын нөлөө туссан болохыг дурдах хэрэгтэй.

Тайлангийн уг бүлгийг:

1. Монгол Улсаас гадаад улсын чиглэлд
2. Гадаад улсаас Монгол Улсын чиглэлд
3. Монгол Улс дотоодод гэсэн гурван дэд бүлэгт хуваан тайлбарлалаа.




1.1. Гадаад улсад үйлдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэл

Монгол Улсаас гадагшаа улс хооронд үйлдэгдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэлийн хүрээ нь газар зүйн хувьд ойр Азийн улс орнуудад илүүтэй төвлөрч байгаа боловч дэлхийн маш олон оронд Монгол Улсын иргэд худалдаалагдаж хохирогч болсон тохиолдлууд бүртгэгдсэн байна.

ХХГХ-ийн чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, хохирогчдыг эгүүлэн татах үйл ажиллагаа зохион байгуулж, хамтарч ажилласан орнуудыг харгалзвал ХХГХ-ийн төрөл хэлбэрээс хамааран зонхилж буй урсгал чиглэлд ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, бэлгийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ үйлдэгдэж буй чиглэлийг авч үзвэл Монгол Улсаас Зүүн болон Зүүн Өмнөд Азийн улс орнууд уруу чиглэсэн урсгал зонхилсон, Европ, Америкийн орнуудад цөөн тоогоор илэрч бүртгэгдсэн байна. Тодруулбал, БНХАУ, Хонгконг, Макао, Малайз, Камбож, Филиппин, Япон, БНСУ орнуудад хохирогч бүртгэгдсэн тооны хувьд бусад улс орноос өндөр, үүнээс гадна Герман, Швед, Бельги, Турк, АНУ⁴ зэрэг орнуудад хохирогчид бүртгэгджээ. Ингэхдээ сүүлийн жилүүдэд мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, цахим гэмт хэрэг болон бусад төрлийн гэмт хэргүүдтэй хослон үйлдэгдэх болсон талаар албаны эх сурвалж онцолж байв. Энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг тул мөрдөн шалгах ажиллагаа явуулахад цаг хугацаа, хүн хүч ихээр шаардагддаг төдийгүй хохирогч нь нэр төр, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаасаа болоод тэр бүр цагдаагийн байгууллагад ханддаггүй бусад төрлийн гэмт хэрэг шиг бүртгэгддэггүй мөрдөгчөөс илрүүлж бүртгүүлдэг онцлогтой юм.

Зураг 3. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд



Эх сурвалж: ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022

⁴ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

Албадан хөдөлмөр эрхлүүлэх чиглэлд БНХАУ, Энэтхэг, Казакстан, Норвег, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад⁵ дурдагдсан байгаа бөгөөд сүүлийн 10 жилд ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор Монгол Улсаас гадагшаа чиглэсэн хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний урсгал эрчимтэй нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Зураг 4. Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд



Эх сурвалж: ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022

Монгол Улсын Засгийн газар, Гадаад харилцааны яам (ГХЯ)-ны мэдээллээр 2018-2020 оны хооронд 61 иргэнийг, цагдаагийн байгууллагын мэдээллээр 42 иргэнийг эх оронд эгүүлэн авчирчээ. Уг тоон мэдээлэл нь тухайн хохирогч аль байгууллагад түрүүлж хандаж, хамтран ажилласнаас хамаарч байна⁶.

Хүснэгт 1. Гадаад улсаас эх оронд нь эгүүлэн авчирсан хохирогчдын тоо

Эх сурвалж	2018	2019	2020
ГХЯ-аас ирүүлсэн мэдээллээр	БНХАУ-28 АНУ-1	Камбож улс-4 Бүгд найрамдах Киргиз улс-1 Филиппин улс-1 БНХАУ-17 Сингапур-4	Малайз улс-5
Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн мэдээллээр	БНХАУ-14 Малайз-2 Мьянмар-3 Камбож-4	Турк-1	Малайз улс-18

Эх сурвалж: ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022

⁵ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалэх асуудлын төлөв байдлын тухай тайлан

⁶ Мөн тэнд



Монгол Улс сүүлийн жилүүдэд гадаадад ХХГХ-т өртөж хохирсон иргэдийг эх оронд нь эгүүлэн авчрах асуудалд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд сүүлийн гурван жилийн байдлаар Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудаас хохирогчдыг эгүүлэн татсан байна. Цар тахлаас үүдэлтэй хилийн хориг, хөл хориотой холбоотойгоор дэлхийн ихэнх улс оронд ХХГХ-ийн гадагшаа чиглэсэн урсгал саармагжиж, эсрэгээр дотоод хөдөлгөөн нэмэгдсэн. Үүнийг дагаад цар тахлын дараа улс орнуудын хилийн хориг сулармагц олон улсын хөдөлгөөн нэмэгдэх эрэлтийг дагаад ХХГХ-ийн тохиолдол улам нэмэгдэх эрсдэлтэй. Тухайлбал, цар тахлын дараа Бүгд Найрамдах Турк Улс хамгийн анх хилээ нээж хэвийн үйл ажиллагаанд шилжсэнээр Монгол Улсын иргэд тус улс руу зорчих, дамжин өнгөрөх хөдөлгөөн эрс нэмэгдэж байна. Тус улсын Истанбул хотын Таксимийн төв талбай орчим цэнгээний газарт хэсэг бүлэг Монгол эмэгтэйчүүд биеэ үнэлж байгаа нь тэнд ХХГХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа талаар Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэлд дурдагджээ⁷.

Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд нь ХХГХ-ийн хохирогч болох хамгийн эрсдэл бүхий бүлэгт тооцогдсоор байгаа бөгөөд хил залгаа болон хүн ам ихээр суурьшсан хотуудад анх удаа биеэ үнэлэх ажил хийхээр ирсэн Монгол охид, эмэгтэйчүүдийг өөрсдийн эрхшээлдээ оруулах зорилгоор гадаад паспортыг нь хураан авч зорчих эрхийг нь хязгаарлан хилээр буцаан гаргахгүй, визний хугацааг санаатайгаар хэтрүүлэн ХХГХ-ийн хохирогч болгож буй тохиолдлууд нийтлэг байна. Мөн гэмт этгээдүүд хохирогчдыг өөрсдийг нь Монгол Улсаас өөр бусад охидыг элсүүлж авчруулах шаардлага тавьж гэмт этгээд болгож байгаа нь гэмт этгээдүүд баригдахгүй байх, Эрүүгийн хариуцлагаас мултрах гол арга нь болж байгааг холбогдох мэргэжилтнүүд онцолжээ.

Мөн ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудад бэлгийн цөөнх буюу ЛГБТ хүмүүсийн асуудал орхигддог бөгөөд хэдийгээр ЦЕГ-т ХХГХ-ийн ЛГБТ хохирогч бүртгэгдээгүй ч хэлэлцүүлэгт⁸ дурдагдсанаар тэд хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлт бүлгийн нэгд тооцогдож байна.

1.2. Гадаад улсын иргэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болох эрсдэл

Одоогийн байдлаар гадаадын иргэд Монгол Улсад хөдөлмөр болон бэлгийн мөлжлөгт өртөн шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол гараагүй байна. Гэсэн хэдий ч энэ чиглэлд хийгдсэн олон судалгааны тайланд гадаадын иргэд Монгол Улсад ажиллаж хөдөлмөрлөх явцдаа мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байгааг дурджээ. Тодруулбал, гадаад улсын иргэдийг авчирч ажиллуулж байгаа Монгол дахь ажил олгогчид санаатайгаар цалин хөлсийг нь өгөхгүй удааснаар гадаад ажилтнаа хууль бус оршин суугч болгож⁹ гадаад иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Гадаадын иргэн харьяатын газар)-д хандан албадан гаргуулах хүсэлтийг гаргаж тухайн иргэний хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох зөрчил гардаг байна. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд гадаад иргэд хөдөлмөрийн хөлсөө авч чадалгүйгээр Монгол Улсаас албадан гаргуулах буюу хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэлтэй байна. Ялангуяа Монгол Улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй ажилчид ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна¹⁰.

⁷ Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн мэдээлэл

⁸ Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд зохион байгуулагдсан "Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл хэлэлцүүлэг"-т танилцуулсан ХХГХ-ийн чиг хандлага, түүнтэй тэмцэхэд тулгарч буй асуудал судалгааны үр дүнгийн хэсгээс, 2022., УБ

⁹ Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар визний хугацаа хэтэрснээс хойш 2 сарын хугацаанд албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд албадан гаргах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

¹⁰ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалэх асуудлын төлөв байдлын тухай тайлан

Тухайлбал, 2020 оны 09 дүгээр сард Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байсан Мьянмар Улсын гурван иргэн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн гэдэг үндэслэлээр хуулийн байгууллагад хандсан бөгөөд тэднийг хамгаалах, туслалцаа үзүүлэх ажиллагааг ОУШХБ, ХТЭТ ТББ-ууд хамтран зохион байгуулсан. Гэвч тэдгээр иргэдийг холбогдох байгууллагуудаар дамжуулан нутаг буцааж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн хугацаанд хийгдсэн ижил төстэй судалгааны тайлангуудтай танилцах явцад гадаадын иргэн ажиллуулах ажлын байрны төлбөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдан нэмэгдэж буй, мөн аж ахуй нэгжийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалаад хөдөлмөрийн визээр бус, бизнес болон жуулчлалын визээр буюу өөр ангиллын визээр гадаадын иргэд хил нэвтэрч орж ирэх болсон нь гадаад иргэдийн эмзэг байдлыг далимдуулах, хохироох, мөлжих эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна.

Зураг 5. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд, хөдөлмөр эрхлэх визтэй иргэдийн ажиллаж буй салбар



Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ)-ын 2021 оны IV улирлын мэдээллээр Монгол Улсад нийт 123 орны 16,111 иргэн долоон төрлийн визний ангиллаар түр болон байнгын зөвшөөрөлтэйгөөр оршин сууж байна. Тэдгээрийн 34% (n=6,239) нь хөдөлмөр эрхлэгч ангиллаар оршин сууж байгаагийн бараг хоёр хүн тутмын нэг нь уул уурхай, олборлолт болон барилгын салбарт ажиллаж байна (Зураг 5). Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийг улс орноор нь харвал БНХАУ, ОХУ, Вьетнам, БНСУ, Энэтхэг, Австрали Улсын иргэд давамгайлж байгаа бөгөөд байршлын хувьд Улаанбаатар, Дорнод, Өмнөговь, Дорноговь аймгуудад зонхилон ажиллаж байна.



Хүснэгт 2. Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд, улс орноор, нийтлэг ажлын байраар

№	Улс	Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо	%	Хөдөлмөр эрхэлж буй нийтлэг ажлын байр
1	БНХАУ	3531	62.8	Барилга, зам гүүр
2	ОХУ	272	4.8	Сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын салбарт
3	Вьетнам	234	4.1	Авто засвар
4	БНСУ	220	3.9	Зоогийн газар, гоо сайхан, үйлчилгээний салбарт
5	Австрали	134	2.3	Уул уурхай, хүнд үйлдвэр
6	АНУ	111	1.9	Уул уурхай, хүнд үйлдвэр
7	Филиппин	105	1.8	Хүүхэд асрагч, гэрийн үйлчлэгч
8	Өмнөд Африк	103	1.8	Спорт
9	Англи	62	1.1	Боловсрол
10	Канад	57	1.0	Уул уурхай, хүнд үйлдвэр
11	Япон	47	0.8	Массажист, гэрийн үйлчлэгч
12	Казахстан	36	0.6	Массажист, гэрийн үйлчлэгч
13	Бусад	705	12	Массажист, гэрийн үйлчлэгч

Эх сурвалж: Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн мэдээлэл, 1212.mn

Мөн гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан ОХУ, БНХАУ зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй мэдээллүүд холбогдох тайлангуудад туссан байна.¹¹

Гадаад улсын иргэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй тохиолдлууд бүртгэгдэж байгаа хэдий ч энэ тохиолдолд гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалах, тусламж үзүүлэх, эрхийг нь хамгаалахад хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдлууд байгаа нь цаашид гаднын иргэдийг хохироох асуудалд бүрэн хяналт тавих боломжийг хязгаарлаж байна. Иймд цаашид ГИХГ болон хөдөлмөрийн хяналт шалгалтын асуудал хариуцсан байгууллагууд гадаад иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гадаад иргэдийн эрх, ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалах зайлшгүй шаардлага байгаа нь харагдаж байна.

¹¹ U.S Department, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

1.3. Дотоод дахь ХХГХ-ийн урсгал чиглэл

Дотоод дахь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртүүлж буй ихэнх тохиолдлууд Улаанбаатар хотод бүртгэгджээ. Тодруулбал, 2019-2021 оны хооронд бүртгэгдсэн 65 хэрэгт 131 хохирогч тогтоогдсоны 66%¹² нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна¹³. Ингэхдээ бусад дүүргүүдээс илүү Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт энэ төрлийн гэмт хэргүүд илүү бүртгэгдсэн. Сонгинохайрхан дүүрэгт гарсан гэмт хэргийн 57.1% нь Саппоро төвийн орчимд, Баянзүрх дүүрэгт гарсан гэмт хэргийн дийлэнх нь буюу 30.8% Хүнс, хөдөө аж ахуйн яамны ойролцоох автобусны буудлын орчимд үйлдэгдсэн байна¹⁴.

Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) ТББ-аас 2022 онд хийсэн судалгааны үр дүн¹⁵-ээр хуулийн байгууллагад хандаж туслалцаа авсан 20 хохирогчийн кейс мөн ижил үр дүнг харуулж байгаа бөгөөд тэдгээрээс дотооддоо хохирогч болсон 12 эмэгтэйчүүд бүгд Улаанбаатар хотод худалдаалагдаж, нэг дүүргээс нөгөө дүүрэгт зуучлагчийн хамт явж үйлчилгээ үзүүлэх, эсвэл нэг байршилд хоригдож бэлгийн мөлжлөгт өртөж байжээ¹⁶. ХХГХ-ийн тохиолдол Улаанбаатар хотод өндөр байгаа нь нэг талаас хот, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн боломжууд хотод илүү төвлөрч байгаатай холбоотой, хоёрдугаарт уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны чадавх мөн хотод илүү төвлөрч байгаатай холбон тайлбарлагдаж байна.

Хэргийн илрүүлэлт, илэрсэн хэргийн давтамжийг харгалзвал орон нутгуудаас хилийн ойролцоох аймаг, сумд дараагийн эрсдэлтэй бүсэд тооцогдож байна. Ялангуяа Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа БНХАУ-Монголын хилийн эргэн тойронд ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Өмнөговь аймагт БНХАУ-ын хилээр нүүрс тээвэрлэж буй ачааны машины жолооч нарын паспортыг ажил олгогчид нь тээврийн хэрэгслийн барьцаа болгож хураан авч байгаа нь тэднийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх нэг хүчин зүйл болж байна.

ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлэгч хүчин зүйлсийг харгалзан аймаг орон нутгийн эрсдэлийг тодорхойлохыг оролдсон. Үр дүнгээр ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй нийгэм, эдийн засгийн дараах хүчин зүйлсийг харгалзан гурав болон түүнээс дээш сөрөг үзүүлэлтүүд давхцаж буй орон нутгуудыг эрсдэл өндөр бүсэд тооцов¹⁷. Үүнд:

- Ядуурал их. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх ихтэй
- Гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр
- Гэмт хэргийн гаралт өндөр
- Шилжилт хөдөлгөөн ихтэй
- Хөдөлмөр эрхлэлт бага
- Сургуульд хамрагдалтын түвшин бага

¹² 2019-2021 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн 131 хохирогчийн 66% (n=87) нь Улаанбаатар хотод, 6 хэрэг Өмнөговь аймагт, 38 нь хилийн чанадад бүртгэгдсэн байна.

¹³ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, УБ., 2022

¹⁴ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас өгсөн мэдээллээр, 2022/07/06

¹⁵ ХТЭТ ТББ, Хүн худалдаалах түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх дүн шинжилгээ судалгааны тайлан, УБ., 2022.


¹⁶ Азийн сан, ХТЭТ ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2022

¹⁷ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, УБ., 2022



Эдгээр макро түвшний хүчин зүйлсээс гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх Монгол хохирогчдыг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, ХХГХ-ийн хохирогч болгоход хүргэж, гэмт этгээдүүдийн гарт ороход нь нөлөөлж байгааг ижил төстэй олон судалгааны үр дүн нотлон харуулж байв. Энэхүү эмзэг байдал нь цар тахлын үед тогтоосон хөл хорионы үед илүү өссөн нөхцөл байдалтай байна¹⁸.

Зураг 6. ХХГХ үйлдэгдэх эрсдэл бүхий байршлууд, эмзэг хүчин зүйлээр



Эрсдэлт хүчин зүйлсийн давхардлыг авч үзвэл Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотын араас БНХАУ-тай хил залгаа Өмнөговь, Дорноговь аймгууд хамгийн эрсдэл өндөр орон нутагт тооцогдож байна.

Дотоодод гэмт этгээдүүд цахим орчныг ашиглан “Санхүү авна, өгнө” гэх зар байршуулж охид, эмэгтэйчүүдийг эрхшээлдээ оруулж, зодож, айлган сүрдүүлж хүчиндэх, нүцгэлж дүрс бичлэг хийж “Олон нийтийн сүлжээнд тавина, цагдаад өгнө” гэх зэргээр эрхшээлдээ оруулж, орон сууц, нийтийн байр хөлслөн зорчих эрхийг нь хязгаарлан хорьж, бусдад хүчээр биеийг нь үнэлүүлж ХХГХ үйлдэж байгаа талаар ЭЦА-аас мэдээлсэн. Түүнчлэн ЛГБТ хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал¹⁹ байдлаас нийгмийн зүгээс гадуурхах явдал өндөр байдаг нь мөн улмаар эдгээр бүлгийн иргэдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хохироох эрсдэлийг бий болгож байна²⁰.

¹⁸ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

¹⁹ Мөн тэнд

²⁰ Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл

Дэлхий даяар цахим орчны хэрэглээ өсөн нэмэгдэж, сошиал хуудсанд иргэдийн хувийн зураг, мэдээлэл нь нээлттэй байрлах, хувийн хэрэгцээ, сэтгэл зүйн төлөв байдлаа нээлттэй илэрхийлж буй байдлууд нь гэмт хэрэгтнүүдэд хохирогчдыг олзлоход давуу талыг үүсгэж байна.

Мөн Монгол Улс сошиал медиа (Facebook, Instagram, TikTok, Likee г.м) хэрэглээ маш өндөр бөгөөд фейсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2020 онд 2.1 сая, 2021 оны 2.2 сая байгаа нь хүн амын тоотой харьцуулахад хэрэглээгээрээ дэлхийд эхний аравт багтаж байна²¹. COVID-19 цар тахлын үед бүх нийтийн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор насанд хүрсэн иргэдийн төдийгүй хүүхдүүдийн сошиал хэрэглээ огцом нэмэгдсэн ба тогтоосон насны хязгаараас бага, 14 насанд хүрээгүй хүүхдүүд ч сошиал орчинд хэд хэдэн хаяг ашиглаж буй нөхцөл байдалтай байна.

Сүүлийн үед сошиал медиа хэргэлээ ихэссэний улмаас зохион байгуулалттай биеэ үнэлэлт цахим орчинд үйлдэгдэх нь эрс нэмэгдэж байна. Тухайлбал, цахим орчныг өргөнөөр ашиглаж биеэ үнэлэхийг зохион байгуулах зорилгоор Facebook групп, цахим хуудаснууд олноор нээгдэж энэ төрлийн гэмт хэрэг далд хэлбэрээр үйлдэгдэж байна. Эдгээр цахим хуудаснуудад тавьсан заруудын дагуу санхүү авна гэх охид, эмэгтэйчүүдийг клиент /үйлчлүүлэгч/ нэрээр гэмт этгээдүүд олзлон авч, гар утас, мөнгө, эд зүйлийг нь дээрэмдэх, хохирогчийг нүцгэлж дүрс бичлэг хийн тохуурхан даажигнаж олон нийтийн сүлжээнд байршуулах, ойр дотнын, гэр бүлийн хүмүүст нь тухайн хийсэн дүрс бичлэгийг үзүүлж биеэ үнэлэгч гэдгийг нь илчлэх зэргээр амь нас, эрүүл мэнд, нэр хүнд, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаар нь далимдуулан өөрсдийнхөө эрхшээлд оруулж бусдад хүчээр биеийг нь үнэлүүлж ХХГХ-ийн золиос болгож байна. Цахим орчны хяналтгүй байдал, интернэтийн зохисгүй хэрэглээнээс үүдэн охид, эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн хохирогч болж байгааг мэргэжилтнүүд онцолж байна.

²¹ Digital 2020: Mongolia

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО



2.1. Урьдчилан сэргийлэх

2.1.1. Төрийн байгууллагууд

2.1.2. Олон улсын байгууллагууд

2.1.3. Төрийн бус байгууллагууд

2.2. Хохирогч хамгаалал

2.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

2.4. Хамтын ажиллагаа

2.4.1. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа

2.4.2. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын
байгууллагын хамтын ажиллагаа

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО

2.1. Урьдчилан сэргийлэх

ХХГХ-тэй тэмцэх гол үйл ажиллагаануудын нэг нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан тогтолцооны оролцогч байгууллагуудын урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудаас үзэхэд Монгол Улсын Засгийн газар ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа жил ирэх тусам нэмэгдүүлж байна.

ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд талуудын авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгтгэн үзвэл боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах, туршлага солилцох, судалгаа хийх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, мэдээлэл өгөх үйл ажиллагаа зонхилж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн сургалтуудын тойм

Хугацаа	Хийгдсэн ажлууд	Оролцогч талууд
2019	ХЗДХЯ нь Азийн сантай хамтран хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан хоёр удаагийн сургалтад ДХИС-ийн 510 сонсогч, найман удаагийн мэргэшүүлэх сургалтад 198 орчим шүүгч, прокурор, цагдаагийн болон ХХЕГ, ГИХГ-ын албан хаагчид хамрагдсан ²² .	ГХУСАЗЗ, ДХИС, Азийн сан
2019	ЕБС-ийн 11-р ангийн “Эрүүл мэнд” хичээлийн “Хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн эсрэг тэмцэх арга зам” сэдвийн агуулгад Хүний наймааны гэмт хэрэгт өртөх нь сэдвийг багтаан зааж байна.	БШУЯ
2019	Гадаад улс дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа 30 консулын ажилтнуудыг ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр цахим сургалтад хамруулсан.	ГХЯ
2019	ЦЕГ-ын Зохион байгуулалттай гэмт хэрэг, ХХГХ-тэй тэмцэх тасаг болон Хууль сахиулах сургуулийн төлөөлөл 10 ажилтан БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулсан ОУШХБ-ын хуралд оролцон ХХГХ-тэй тэмцэхэд хоёр улсын хамтын ажиллагааг үйл ажиллагааны түвшинд сайжруулах зорилтын хүрээнд ижил чиг үүргийн цагдаагийн албан хаагч нартай туршлага солилцсон.	ЦЕГ
2019	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд мэргэшүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх сэдэвт сургалтыг Хууль сахиулах байгууллагын 49 албан хаагчид, УЕПГ-ын 19 прокурор нарт зохион байгуулав.	ЦЕГ, Анбаунд Монгол ТББ

²² <https://www.facebook.com/TheAsiaFoundationMongolia/>



2019	15-18 насны 5000 охид, өсвөр үеийнхэнд жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой 250 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн “Цахим орчин дахь ухаалаг хэрэглээ” зөвлөгөө мэдээлэл бүхий постерыг өсвөр үеийнхэн, залуучуудад сургалтын үеэр түгээсэн.	Хөөрхөн зүрх ТББ
2020	“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа – хохирогч төвтэй хандлага төлөвшүүлэх” сургалтаар Эрүүгийн цагдаагийн алба болон харьяа нутаг дэвсгэрийн нэгжүүдийн эрүүгийн мөрдөгч, хороо хариуцсан хэсгийн байцаагч зэрэг 30 гаруй албан хаагч хамрагдсан.	Азийн сан, ХТЭТ ТББ
2020	ОУХБ-ын 3R (rights, responsibilities and representation) сургалтын хэрэгсэл нь хүүхэд, залуучууд, тэдний гэр бүлийнхэн, ялангуяа хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ-ийн хохирогч болох эрсдэл өндөртэй нөхцөлд амьдардаг хүүхэд эмэгтэйчүүдийг чадавхжуулахад зориулагдсан. Уг сургалтыг 2020 оны 1 сары болон 2022 оны 12 сард тус тус зохион байгуулагдсан бөгөөд найман мастер сургагч багш, хүүхэд, залуучууд, гэр бүлтэй ажилладаг төрийн болон төрийн бус 30 ажилтныг зорилтот бүлгийн иргэдийг сургах сургагч багшаар бэлтгэсэн байна ²³ .	ОУХБ
2019-2021	Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод туслалцаа үзүүлэх” сэдэвт 19 удаагийн сургалтаар сургагч багш нарыг бэлдэж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.	ХНХЯ, БНСУ-ын Жендерийн тэгш эрх, гэр бүлийн яам, ХТЭТ ТББ

Сүүлийн гурван жилийн (2019-2021) хугацаанд төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтуудыг танхим болон цахимаар хослуулан зохион байгуулсан нь ХХГХ-ийг зөвхөн бэлгийн мөлжлөг бус бусад төрөл, хэлбэрээр илэрч болох өргөн хүрээний ойлголт болохыг таньж мэдэх, хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэхэд чухал түлхэц болохуйц ажлууд явагдсан байна (Хүснэгт 3). Түүнчлэн ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын зарим төлөөлөл гадаад улс оронд туршлага судалжээ. Гадаад улс руу туршлага судлах сургалтууд нь энэ чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг чадваржуулахад томоохон дэмжлэг болж байгаа ч албан хаагчдыг тогтвор суурьшил нь эдгээр ажлын үр дүнг бууруулж байгааг байгааг байгууллагын төлөөллүүд дурдсан.²⁴

ЕБС-ийн суралцагчдад ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгож байна. Сүүлийн жилүүдэд цахим орчинд хүүхэд, насанд хүрэгчид ХХГХ-ийн хохирогч болох хандлага нэмэгдэж байгаатай холбоотойгоор цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар сургалтуудыг зохион байгуулсан нь энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажлын нэг байна. Түүнчлэн ГХУСА33-ийн ажлын алба, БШУЯ хамтран “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийг байгуулан ажиллуулсан сайн туршлага байна.

²³ Холбос: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_754531.pdf

²⁴ Азийн сан, ДЗМОУБ, Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаа: асуудал, шийдэл, хэлэлцүүлэг, Улаанбаатар, 2022.

Хүснэгт 4. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн судалгааны ажлуудын тойм

Хугацаа	Хийгдсэн ажлууд	Оролцогч талууд
2019	"Биеэ үнэлэлт ба бэлгийн мөлжлөгийн эмзэг байдал"-ын судалгааг гүйцэтгэв.	ХНХЯ, ТББ
2019	Морь унаач хүүхэд болон хүүхдийн хөдөлмөр хамгааллын асуудлаар тус бүр томоохон хэмжээний судалгааг хийсэн.	МХЕГ
2020	Монгол Улсын ХХГХ-тэй холбоотой хууль тогтоомжид хийх үнэлгээ, Монгол дахь ХХГХ-ийн хохирогчдын эрсдэлийн хүчин зүйлсийн шинжилгээ, Сошиал медиагаар дамжуулан хүүхдийн хүчирхийллийн талаарх нийт гурван судалгааг хийсэн.	ХЗДХЯ, ГХУСАЗЗ
2020	"Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам" судалгааны ажлыг гүйцэтгэв.	НҮБ, Хүүхдийн сан, ДХИС
2021	"Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл (2019-2021 оны III улирал)" судалгааг хийв.	УЕПГ
2021	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас 2020, 2021 онуудад "Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал" судалгааг хийв.	ЦЕГ
2021	"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал" судалгааны ажлуудыг гүйцэтгэв.	Азийн сан, ХТЭТ ТББ
2021	Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, ХХГХ-т өртөмтгийн болон тэсвэртэй байдлын суурь судалгааг гүйцэтгэв.	ОУШХБ, IRIM
2021	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: "Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" төслийн суурь судалгаа, "Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал" судалгааг тус тус хийв.	ДЗМОУБ, Азийн сан, IRIM

2019-2021 оны хугацаанд үндэсний хэмжээний нийт есөн судалгаа хийсэн бөгөөд 2021 онд голлох, үндсэн суурь судалгаануудыг хийж гүйцэтгэсэн байна. Судалгаануудын агуулга нь ХХГХ-ийн өнөөгийн байдал, тогтолцооны зураглал, шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлүүд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, урьдчилан сэргийлэх арга замуудыг түлхүү харуулахыг зорьжээ. Судалгааны ажлуудын дийлэнхийг ОУБ-уудын санхүүжилтээр судалгааны мэргэшсэн компаниуд болон ТББ-ууд хийж гүйцэтгэсэн (Хүснэгт 4). Гэвч эдгээр судалгааны үр дүн, холбогдох зөвлөмжүүдийг хэрхэн авч хэрэгжүүлсэн талаар мэдээлэл хомс байв.

Хүснэгт 5. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах ажлуудын тойм

Хугацаа	Хийгдсэн ажлууд	Оролцогч талууд
2019	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлан мөрдөж байна.	УИХ, ХЗДХЯ
2019	"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь" төслийн хүрээнд Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн танхимыг нээсэн.	ХЗДХЯ, ДХИС, Азийн сан



2019-2021	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг хэлэлцэн батлах, хэрэгжүүлэх, дүгнэх ажлуудыг хийсэн.	ГХУСА33
2021	Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтад дүн шинжилгээ, Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал тодорхойлох судалгааг хийж, судалгааны зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалаа боловсруулж, УИХ-аар батлуулахаар ажиллаж байна.	ХНХЯ, ХЗДХЯ
2021	Хилийн гадна амьдарч байгаа хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад тулгуурлан олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэхээр ажиллаж байна.	ХНХЯ, ГХЯ
2021	Монголд хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдтэй хийсэн хөдөлмөрийн гэрээ нь мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцэж буй эсэхэд хяналт тавьж, хөдөлмөрийн нөхцөлд шалгалтыг хийсэн.	МХЕГ
2021	Салбар дундын хамтарсан багийг байгуулан ажиллаж байна.	ГХУСА33

Судалгааны үр дүнгээр ГХУСА33-ийн ажлын албанаас ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд холбогдох байгууллагуудаар нэгдсэн төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, чиг үүргийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнаж байгаа нь салбарын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад түлхэц болж байна. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Монгол Улсын Засгийн газар ихээхэн анхаарал хандуулж, ОУБ-уудаас техникийн туслалцаа, дэмжлэг, зөвлөгөөг авсан. Үүний үр дүнд олон улсын гэрээ конвенцуудыг соёрхон батлах, хуулийг шинэчлэх, шаардлагатай бүтцийг бий болгох, үйл ажиллагааг тогтворжуулах, хяналт шалгалтыг сайжруулах, эрчимжүүлэх ажлууд хийгдсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 6. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн үндэсний аяны ажлуудын тойм

Хугацаа	Хийгдсэн ажлууд	Оролцогч талууд
2021	Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой “Мөрөөдлийн шүхэр” үндэсний аян зохион байгуулав.	ГХУСА33, ОУШХБ
2019, 2020, 2021	ХХГХ-ийг таслан зогсооход өөрийн үзэл бодол, дуу хоолойгоо нээлттэй илэрхийлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх амьдрах ухааны боловсролыг олон нийтэд өгөх, даван туулагчдаа эв санаа нэгтэй байгаагаа түгээх зорилготой “Хөх зүрх аян”-д нэгдсэн.	ОУШХБ, Анбаунд Монгол ТББ
2021	“Not in my city” /Миний хотод биш/ аяныг зохион байгуулж, мэдээллийн платформ хөгжүүлсэн.	ЦЕГ, Анбаунд Монгол ТББ
2019, 2020, 2021	Жендэрт суурилсан бүхий л хүчирхийллийг таслан зогсоох, жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан, нөлөөллийг олон нийтэд таниулах, урьдчилан сэргийлэх, хохирогчийг буруутгах хандлагыг таслан зогсоох зорилготой “Тэрбумаараа тэмцье” хөдөлгөөнийг үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулав.	Хөөрхөн зүрх ТББ

ОУБ, ТББ-ын оролцоо, дэмжлэгтэйгээр 2019-2021 оны хугацаанд гурван үндэсний аян, нэг хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд амжилттай зохион байгуулсан (Хүснэгт 6). Тухайлбал, “Мөрөөдлийн шүхэр” үндэсний аяныг зохион байгуулснаар ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийн хандалт нь нийгмийн сүлжээнд 26 саяд хүрч, алга болсон 12 хүүхэд олдсон. Тус кампанит аяны хүрээнд контентуудыг хэрэглэгчийн зан төлөвийн судалгаанд үндэслэн бүтээж, гудамж талбайн сурталчилгаа, биет түгээлт, VR технологи, анимэйшн зэргийг нөлөөллийн ажлын нэг хэсэг болгосон нь тодорхой үр дүнд хүрчээ.

Хүснэгт 7. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн мэдээлэл, сурталчилгааны ажлуудын тойм

Хугацаа	Хийгдсэн ажлууд	Оролцогч талууд
2019	Хилийн хяналтын байгууллагын албан хаагчид 50,000 орчим монгол иргэний паспортад, үүнээс 1,000 гаруй хүүхэд байсан ба ХХГХ-ийн эрсдэл, хохирогчийн үйлчилгээ авах боломжийн талаарх мэдээлэл, тайлбар бүхий хуудсыг хавсаргасан тараасан.	ХХЕГ
2019, 2020	Хүн худалдаалах, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага-9, зурагт хуудас-40, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж-20, нийт 4047 ширхгийг нисэх буудал, олон улсын чанартай хилийн боомтууд, ОХУ-Монгол улс-БНХАУ зэрэг 3 улсыг холбосон төмөр замын гол шугамд, автобусны буудал, томоохон худалдааны төвүүдэд олон нийтэд тарааж, сурталчилсан.	ЦЕГ
2020	Хүүхдийн тусламжийн 108 утсаар мэдээлэл хүлээн авах эх сурвалж нэмэгдэж чатбокс, мессеж (sms) ашигладаг болсон.	ГБХЗХГ, ДЗМОУБ
2019, 2020, 2021	БНСУ-ын Засгийн газартай хамтран ХХГХ-тэй тэмцэх ажлын хүрээнд мэдээллийн материалыг үргэлжлүүлэн гаргасан.	ХНХЯ, БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яам
2019, 2020, 2021	Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл, зөвлөгөөг өгөх Итгэлийн утас 1800-1903 утсыг ажилуулснаар бэлгийн хохирогч болсон байж болзошгүй нэг хэргийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн.	ХНХЯ, ХТЭТ ТББ
2020, 2021	Хохирогчийн түүхээр баримтат кино, нэвтрүүлэг, анимэйшн, брошюр, гарын авлага, контент бэлтгэн түгээв.	ХТЭТ ТББ, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ
2021	“Нарны сүүдэр” уран сайхны киног бүтээн нээлтээ хийсэн.	ГХУСА33, НҮБ-ын ХАС, Онч мэргэн продакшн

ХХГХ-ийн талаар төрийн болон ТББ, ОУБ-ууд хамтран эсвэл бие даан иргэдэд мэдээллийн хуудас, хохирогчийн түүхээр баримтат кино, нэвтрүүлэг, анимэйшн, брошюр, гарын авлага, видео шторк, контент, цахим хуудсын чатбокс, мессеж зэрэг олон талт байдлаар хүргэсэн (Хүснэгт 7). Тухайлбал, Цагдаагийн байгууллагаас ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 21 удаа, 96 минутын нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллээр 31 удаагийн давталттайгаар иргэд, олон нийтэд хүргэсэн байна. Цахим хуудсаар нийт 599 мэдээ, мэдээллийг цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсныг давхардсан тоогоор 2,037,288 иргэн үзсэн²⁵. ГХУСА33-ийн санаачилгаар

²⁵ ГХУСА33, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 32 хуудас.



хүчирхийллийн хоруршгийн талаар иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Нарны сүүдэр” уран сайхны киног бүтээн нээлтээ хийсэн. Уг кино нь хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай, хүчирхийллийн хажуугаар хэн ч дуугүй өнгөрч болохгүй, нийгэмд хар сүүдэр дагуулсан үйлдлийн төлөө зөв үйлдлийг хийж, дуу хоолойгоо өргөөрэй гэх санааг олон нийтийн мэдээллийн сувгаар үзэгчдэд хүргэхийг зорьсон. Урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй дийлэнх ажлууд тодорхой хугацааны төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгждэг тул ингэхдээ хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны мониторинг үнэлгээг тогтмолжуулах, цаашдын тогтвортой байдлыг хангах ажлуудыг сайжруулахад анхаарах ёстойг судалгааны тайлангуудад онцолжээ.

Тайлангийн дараагийн дэд бүлгүүдэд урьдчилан сэргийлэх чиглэлээр оролцогч талуудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудлыг нарийвчлан авч үзлээ.

2.1.1. Төрийн байгууллагууд

Засгийн газраас баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийн хүрээнд ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхойлогдож байна. Монгол Улсын Засгийн газар Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 432 сая төгрөг (151,650 ам.доллар) төсөвлөснөөс 77% (336 сая төгрөг буюу 117,950 ам.доллар) зарцуулсан, үлдсэн зардлыг COVID-19 цар тахлын хариу арга хэмжээнд ашигласан байна²⁶. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээгээр хөтөлбөрийн нэгдүгээр зорилт болох ХХГХ-ийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах зорилт 93.9%-тай буюу үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэгдсэн. Нэгдүгээр зорилтын эцсийн үнэлгээг дунд хугацааны үнэлгээтэй (74.5%) харьцуулахад 18.5%-аар өссөн нь 2019-2021 оны хугацаанд урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг хийхэд ихээхэн анхаарал хандуулсныг харуулж байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд есөн үйл ажиллагааг үнэлснээс таван үйл ажиллагаа 100% буюу үр дүнтэй, харин хүний эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 77.5%-тай гэж дүгнэгдсэн байна. Мөн ХХГХ-т хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажлын биелэлт 60%-тай гэж үнэлэгдсэн нь цаашид урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарах, хэрэгжилтийг сайжруулахад анхаарах чиглэлүүд байна²⁷. Эндээс үзэхэд ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх төрийн үйл ажиллагааны хэрэгжилт ахиц дэвшил гарч байгаа хэдий ч, холбогдох албан тушаалтнуудын өгсөн мэдээллээр тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг өөр зориулалтад шилжүүлсэнтэй холбоотой зарим үйл ажиллагаа хэрэгжээгүй нь хөтөлбөрийн үр дүнд тодорхой хэмжээнд нөлөөлжээ.

Төрийн байгууллагуудын урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019-2021 оны хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудыг байгууллагуудын хүлээж буй чиг үүргээр нь ангилан, чиг үүргийн дагуу хийгдсэн ажлуудыг холбогдох бичиг баримтуудад үндэслэн авч үзлээ:

²⁶ 2022 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, АНУ-ын Төрийн департамент

²⁷ ГХУСАЗЗ, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 24 хуудас.

Бодлого боловсруулах байгууллагууд: Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, ТББ-тай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлуудыг Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй²⁸. Монгол Улсын Засгийн Газар нь ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд жил ирэх тусам хүчин чармайлтаа нэмэгдүүлж байсныг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнээс харж болохоор байна. Тайлант хугацаанд Засгийн газар нь үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлд түлхүү ажилласан²⁹. Харин ТББ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх чиглэлд хангалтгүй, сул байв.

Үндэсний хөтөлбөрийн дагуу ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд ХЗДХЯ, ГХЯ, ХНХЯ, ЭМЯ, БШУЯ зэрэг байгууллагууд тодорхой чиг үүргийг хүлээсэн. Үүнд:

Хууль зүй дотоод хэргийн яам (ХЗДХЯ) нь төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах чиглэлээр оролцоонд суурилан нэгдсэн төлөвлөгөөг гаргах, батлах, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх ажлуудыг сүүлийн гурван жилд хийж байна. Мөн ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд ОУБ, ТББ-уудтай хамтран суурь судалгааг хийх, үр дүнг тархаах, зөвлөмжүүдийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой үндэсний аян, мэдээлэл, сурталчилгааг үр дүнтэй хийсэн нь тайлангуудаас харагдсан. Гэвч тайлангуудын үр дүнд суурилсан зөвлөмжүүдийг холбогдох байгууллагууд хэрхэн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж буйг хянаж, шалгасан мэдээлэл байхгүй, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагаануудыг цаашид тогтвортой хэрхэн авч явах асуудал тодорхойгүй байна.

Гадаад харилцааны яам (ГХЯ) нь гадаад орнуудад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын ажилтнуудыг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулах, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг эх оронд нь буцаан авчрах тал дээр ХЗДХЯ, ОУБ, ТББ-тай хамтран ажиллаж байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь 2019-2021 оны хугацаанд судалгаа хийх, ХХГХ-т өртөж болзошгүй эсвэл өртсөн хүүхэд, насанд хүрэгчдийг илрүүлэх зорилгоор тусламжийн утас ажиллуулах, мэдээллийн олон талт эх үүсвэрүүдийг ашиглан анхааруулга, мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд хүргэх, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтуудад хамруулах, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чиглэлд илүү төвлөрөн ажилласан байна. Гэвч ХХГХ-ийн хохирогчдыг нөхөн сэргээх чиглэлээр ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулсан талаарх мэдээлэл хомс байна.

Эрүүл мэндийн яам (ЭМЯ) нь ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлгийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах, бүтцийг бий болгох, түүний үйл ажиллагааг тогтворжуулах, эрүүл мэнд болон сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээг үзүүлж байна.

²⁸ УИХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=554>

²⁹ 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, АНУ-ын Төрийн департамент



Гэхдээ баримт бичгийн судалгаагаар ХХГХ-ийн хохирогч нартай ажиллах мэргэшсэн хүний нөөц, холбогдох зардал, нөхөн сэргээх эмчилгээний асуудал өнөөг хэр нь тулгамдсан шинжтэй байгааг дурдах нь зүйтэй.

Боловсрол шинжлэх ухааны яам (БШУЯ) нь ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ЕБС-ийн сургуульд хамтарсан багийг байгуулах, төлөвлөгөөг гарган ажиллах, хичээлийн хөтөлбөрт агуулгыг тусган заах, суралцагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, үндэсний аяныг хамтран зохион байгуулах, хүүхэд өөрийгөө болзошгүй эрсдэлээс хамгаалахад чадварт суралцуулах чиглэлээр ажиллаж байна. Гэхдээ боловсролын салбарын бүх түвшинд насны онцлогоос хамааран ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах, үнэлэх, эцэг эх, асран хамгаалагч нарыг татан оролцуулах ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Хууль сахиулах байгууллагууд: Хууль сахиулах байгууллагууд ХХГХ-ийг илрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг гүйцэтгэнэ. Тухайлбал, Цагдаагийн болон тагнуулын байгууллага нь хүн худалдаалах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаанд хяналт тавьж ажиллах; Хил хамгаалах байгууллага нь хилээр нэвтэрч буй хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, хилийн гадна хүүхэд үлдсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг тодруулах, шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагад шалгуулах шилжүүлэх; Мэргэжлийн хяналтын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын албадан хөдөлмөр, боолчлол, боолчлолтой ижил төстэй нөхцөлд ажиллуулж байгаа эсэхэд мөн иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэхэд бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавихад анхааран ажиллахаар хуульд заасан³⁰. Хууль сахиулах байгууллагуудын тайлант хугацаанд хийгдсэн зарим ажлуудыг дурдвал:

Цагдаагийн Ерөнхий Газар (ЦЕГ) нь урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах сургалтуудыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, гадаад улсын ижил чиг үүргийн байгууллагад туршлага судлах, судалгаа хийх, олон нийтэд чиглэсэн сэрэмжлүүлэг, мэдээлэл сурталчилгааг бэлтгэн хүргэх, олон нийтийн сүлжээнд хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгааг хаах зэрэг ажлуудыг голлон гүйцэтгэжээ. Тодруулбал, 2020-2021 оны хооронд цахим орчинд биеэ үнэлэхийг зохион байгуулж буй нийт 165 фейсбүүк групп, чат, веб хуудас /мессеж зар/-ийг илрүүлж, шалган домэйн хаягийг хандалтыг хязгаарласан байна³¹. Хэдийгээр хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлууд хийгдэж байгаа ч бэлтгэгдсэн албан хаагч тухайн чиглэлээр дагнан ажиллахгүй байгаа нь анхаарлыг татаж байна. Тухайлбал, Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЦЕГ-аас ХХГХ-тэй ажилладаг албан хаагчид таван удаа туршлага солилцох сургалтад гадаад улс руу явж хамрагдсан ч эдгээр албан хаагчдаас нэг ч хүн энэ чиглэлээр ажиллаагүй байна³².

Хил Хамгаалах Ерөнхий Газар (ХХЕГ) нь Хүүхдийг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд Хилийн шалган нэвтрүүлэх журам болон Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмуудыг удирдлага болгон хилээр нэвтэрч буй хүүхдүүдийн бичиг баримтад зохих

³⁰ УИХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=554>

³¹ ГХУСА33, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 29 хуудас.

³² Мөн тэнд, 38 хуудас.

хяналтыг тавьж ажиллаж байна. Хилээр нэвтэрч буй зорчигчдыг хүний биометр мэдээллээр бүртгэх техник хэрэгслийг Чингис хаан боомтод суурилуулсан, түүнчлэн Цагааннуур боомтод 74 сая төгрөгийн үнэ бүхий Дохиолол хяналт хамгаалалтын систем, Буянт-Ухаа, Алтанбулаг, Сүхбаатар, Замын-Үүд боомтод хяналтын камерын нэгдсэн систем нэвтрүүлжээ³³. Мөн ОХУ-Монгол Улс-БНХАУ гурван улсыг холбосон төмөр замын гол шугамд ХХГХ-ийн талаар мэдээлэл, сэрэмжлүүлгийг түгээх ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн уг мэдээллийг орон нутгийн цагдаагийн хэлтсүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тараах зэрэг ажлууд 2019-2021 оны хугацаанд хийгдсэн байна.

2017-2021 оны хагас жилийн байдлаар нийт 396,449 хүүхэд хилээр нэвтэрснээс 1.6% нь буцаж ирээгүй. Албаны хүмүүсийн мэдэгдэж буйгаар гадаад улс оронд суралцах, эцэг эх, асран хамгаалагч дээрээ очих зорилгоор гадаад улсад үлддэг байна³⁴. Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын дагуу ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй сэжигтэй болон хохирогчоор илэрсэн тохиолдолд цааш холбогдох байгууллагад холбон зуучилсан тохиолдол албан ёсоор бүртгэгддэггүй. Одоогийн зохицуулалтаар хэрвээ хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр энэ төрлийн сэжигтэй тохиолдол илэрвэл хил хамгаалах газраас цагдаагийн байгууллагад дамжуулах үүргийг хүлээж байгаа ба ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй иргэдийг хил хамгаалах нэгж дээр илрүүлэх, цааш холбогдох байгууллагад холбон зуучлах чиглэлээрх зохицуулалт зөвхөн хүүхдийг хилээр нэвтрүүлэх уг журмаар хязгаарлагдаж байна. Хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр ажиллаж буй албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны чиг үүрэгт ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүргийг тусгасан заалт байдаггүй, мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал үүсээгүй гэдгийг холбогдох судалгааны тайланд дурдсан байна³⁵.

Гадаадын иргэн, харьяатын газар (ГИХГ) нь ХХГХ-ийн хохирогчийг таних, тогтоох журам, дүрэм, асуулга байдаггүй, албан хаагчид өөрсдийн туршлага, итгэл үнэмшлээр нэмэлт асуулт тавьж, шалгадаг³⁶. ГИХГ нь ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн чанад дахь хүүхэд үрчлэлтийн тоон мэдээ баримтыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд (ҮАБЗ) гаргаж өгч, гадаадад үрчлэгдсэн хүүхдүүдэд үрчлэлтийн дараах хяналтыг журмын дагуу хэрэгжүүлж байна. Тодруулбал, ХБНГУ-д үрчлэгдсэн 16, БНИУ-д үрчлэгдсэн гурав, ИБУИНВУ-д үрчлэгдсэн нэг, АНУ-д үрчлэгдсэн зургаан хүүхдийн нийт 26 тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн³⁷.

ГИХГ нь аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийхдээ хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд зохих ангиллын буюу Монгол улсад хөдөлмөр эрхлэх визтэй эсэхэд хяналт тавьж, харин хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэх, хэрэв байхгүй бол холбогдох байгууллагад хандан хөдөлмөрийн гэрээ байгуулах, зохих ангиллаар урьж ирүүлэхийг зөвлөн ажиллаж байна.

³³ Мөн тэнд, 40 хуудас.

³⁴ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021. 27 хуудас

³⁵ Мөн тэнд, 29 хуудас

³⁶ Г.Оюунболд, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах үйлчилгээний үйл явцыг тодорхойлох нь судалгааны нэгдсэн тайлан, Улаанбаатар, 2022, 16 хуудас.

³⁷ ГХУСАЗЗ, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 41 хуудас.



Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-аас 4.6 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас боловсруулан хяналт шалгалтад нэг мөр хэрэглэх болсон нь барьцаа, хөдөлмөрийн гэрээний асуудлууд хянагдах боломжийг бүрдүүлжээ. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч аж ахуй нэгж, байгууллагад шалгалтыг шууд хийхээр хуульд тусгасан ч хоёр хоногийн өмнө ажил олгогчдод мэдэгдэх гэх шаардлага нь тэдэнд зөрчлөө нуун дарагдуулах хугацаа олгож байж болох юм гэсэн болгоомжлолыг үүсгэж байсан талаар тайлангуудад дурдсан байна. Мөн байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд Монголд хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт шалгалтыг тавин ажиллаж байна. Гэвч улсын байцаагчдад зориулсан санхүүжилт хангалтгүй, хүний нөөц дутмаг болохыг төрийн албан хаагчид болон ТББ-ын төлөөлөл онцолсон.³⁸ Тухайлбал, 2021 оны байдлаар улсын хэмжээнд ердөө 87 хөдөлмөрийн байцаагч байгаа бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт зургаа, нийслэлд 35, үлдсэн нь аймаг орон нутагт ажиллаж байна. Бодит байдал дээр цогц хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн хувьд энэ нь хангалтгүй тоо юм. Мөн албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хянаж шалгах байцаагчдад зориулсан сургалт дутмаг байна. Тухайлбал, 2018-2021 оны хугацаанд хөдөлмөрийн байцаагч нарт чиглэсэн ХХГХ-тэй тэмцэх арга хэмжээний талаар ганцхан удаа сургалт зохион байгуулсан байна³⁹.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагууд: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ХХГХ-ийн хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжих туслалцаа үзүүлэх ажлуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Харин хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ХХГХ-т төртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулахаар хуулинд заасан⁴⁰. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд сургалт зохион байгуулах, үндэсний аян, мэдээлэл сурталчилгааны ажлыг хийсэн. 2019-2021 оны хугацаанд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүүхдийн чиглэлээр хийгдсэн зарим ажлуудыг дурдвал:

Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс хэрэгжиж байна. Хуулийн 52.1-д "Талууд харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж болно", 53.1-д "ажилтан зөвшөөрөөгүй, эсхүл энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажил олгогч хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг ажилтнаас шаардаж болохгүй", 162.2.1-т "хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй" гэж тус тус заажээ⁴¹. Иймд Монгол Улсад хөдөлмөрийн харилцааны нийтлэг үзэгдэл болох ажилчдаас ажилд оруулсны хураамж авах, харилцан зөвшилцөхгүйгээр гэрээг өөрчлөх, цалин хөлсийг барьцааны хэрэгсэл болгох зэрэг асуудлыг гаргасан ажил олгогч, ажилд авагч болон хөдөлмөрийн зуучлагчдад хориг тавих ажлыг холбогдох төрийн байгууллагууд хийх нь чухал.

³⁸ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан.

³⁹ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, УБ.,2022.

⁴⁰ УИХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=554>

⁴¹ УИХ. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2021.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь хилийн чандад амьдарч буй хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад тулгуурлан ХНХЯ болон ГХЯ хамтран хүүхэд хамгааллын тухай олон улсын конвенцуудад нэгдэхээр ажиллаж байна.

ХНХЯ захиалгаар 2020 онд Coram International байгууллагын гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд үндэслэн тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан санал авах ажлуудыг явуулж байна⁴². Тус хуулийн төслийг дагалдан бусад салбарын долоон хуульд нэмэлт өөрчлөлт орох хуулийн төслүүд боловсруулагдаж байгаагийн нэг нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль байна. Тус төсөлд ХХГХ-ийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой заалтуудыг нарийвчилж, хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг боловсруулах, урт хугацааны хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, үүний тулд холбогдох үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүдийг сургаж, чадавхжуулахтай холбоотой үүргүүдийг нарийвчлан тусгаж байна.

Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) нь ХНХЯ-ны харьяа агентлаг бөгөөд Монгол улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэх, гадаад улсын иргэн Монгол улсад хөдөлмөр эрхлэх харилцааг зохицуулахад үүрэг хүлээнэ⁴³. Тодруулбал, 2021 оны Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн хувилбар)-аар хүн худалдаалах, хүн хулгайлах, хууль бус хөдөлмөр эрхлүүлэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг хуульчилсан байна. Тухайлбал:

- 6.2.2 дугаар зүйл заалтад Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээг хүн худалдаалах, хүн хулгайлах, өмчлөх эрхийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон хүн, хуулийн этгээд эрхлэхийг хориглоно;
- 7.1.2 дугаар зүйл заалтад Тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, зуучлах үйлчилгээ үзүүлэх ажилтан нь хүн худалдаалах, хүн хулгайлах, өмчлөх эрхийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж байгаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй хуулийн этгээдэд олгох;
- 25.1.2 дугаар зүйл заалтад өмнө нь хөдөлмөр эрхлүүлж байсан гадаад ажилтны цалин хөлсийг олгоогүй, эсхүл хохирол учруулсан нь тогтоогдсон хуулийн этгээдийн гадаад ажилтныг урих зөвшөөрлийг хязгаарлана;
- 26.1.3 дугаар зүйл заалтад гадаад ажилтныг хилээр орж ирэхээс өмнө байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр тохирсон цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын горим зэрэг гэрээний нөхцөлийг хангаагүй нь тогтоогдсон бол ажил олгогчийн гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг цуцлах;
- 27.1 дугаар зүйл заалтад Гадаадын иргэнийг зохих зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

ХХҮЕГ нь хөдөлмөр эрхлэлт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагын хувьд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажилтан, дадлагажигч гаргах чиглэлийн

⁴² ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021. 26 хуудас

⁴³ 2021 оны Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга. Холбоос: АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ (legalinfo.mn)



үйл ажиллагааг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хариуцаж байна. Монгол Улс хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч илгээх хоёр талын гэрээг БНСУ, Чех болон Япон зэрэг улсуудтай байгуулсан хэдий ч хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлд хийсэн ажлуудын мэдээлэл хомс байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) нь Хүүхдийн тусламжийн 108 утсаар дамжуулан дуудлага, мессеж, чатаар мэдээлэл хүлээн авч, зөвлөгөө өгөх, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш бэлтгэн, аймаг, дүүргийн салбар нэгжүүдээр дамжуулан олон нийтэд сургалт орох ажлуудыг зохион байгуулсан байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 2019-2021 оны дуудлагын нэгдсэн тоон мэдээллээс үзэхэд ХХГХ-ийн асуудлаар 2019 онд дөрөв, 2020 онд хоёр, 2021 онд таван дуудлага бүртгэгдсэн⁴⁴ нь 108 утасны операторуудад хүүхэд уг асуудлаар ханддаг болохыг батлан харуулж байна. Тус газар нь 2017 оноос хойш Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж бүртгэл, мэдээллийг сайжруулахад илүү төвлөрөн ажиллажээ.

Эрүүл мэндийн байгууллагууд: Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэндийн болон сэтгэцийн үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлэгийн ажилтанд сургалт явуулах ажлуудыг хэрэгжүүлэхээр хуульд заасан⁴⁵. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт журмыг хэрэгжүүлэх, бүтэц зохион байгуулалтыг бий болгох чиглэлд анхааран ажилласан байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2013 оны “ХХГХ-ийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх” 462 дугаар тушаалаар батлагдсан журамд эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ) эмийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, заслын эмчилгээг хэрхэн үзүүлэх талаар нарийвчлан зааж өгсөн байдаг. Гэвч энэ журам нээлттэй биш (эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn>, салбарын <https://www.moh.gov.mn> хуудаст байршаагүй), хэрэгжилт хангалтгүй байгааг тайланд дурдсан байна⁴⁶. Эрүүл мэндийн салбарт ХХГХ-ийн хохирогчдод жендэрийн мэдрэмжтэй, сэтгэл зүйн засалд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээ, түүнийг зохицуулсан журам байхгүй бөгөөд хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогч нарт үзүүлэх тусламж үйлчилгээний талаар эмч эмнэлгийн ажилтнуудад тодорхой мэдээлэл өгөх хэрэгцээ байгааг оролцогч талууд илэрхийлжээ.

Донорын тухай хууль 2018 онд батлагдсанаар ЭМЯ-ны харьяа “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба”-ыг тухайн онд байгуулан гадаад улс орон (БНСУ, БНЭУ)-д эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээний асуудлыг зохицуулах бүтэцтэй болсон. Тус алба нь Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/504 “Журам батлах тухай”, 2019 оны А/164 тушаал тус тус баримтлан ажилладаг⁴⁷. Энэ хүрээнд дотоод болон гадаад улс руу эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээнд орох гэж буй иргэд эмнэлгийн тодорхойлолтоос гадна Эс,

⁴⁴ Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийн төв. Дуудлагын нэгдсэн тоон мэдээлэл, Улаанбаатар, 2021.

⁴⁵ УИХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=554>

⁴⁶ ХТЭТ, Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал: Судалгааны тайлан, Улаанбаатар, 2021, 59-60 хуудас, <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>

⁴⁷ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, УБ, 2022. 84 хуудас.

эд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас донорын хамаарлын бичиг бусад холбогдох материалыг тухайн ЭСЯ-д хүргүүлснээр үйлчилгээ авах нөхцөл бүрдэж байна.

Боловсролын байгууллагууд: Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын байгууллага, оюутан, сурагчдын дунд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, стандартад тусгах ажлыг хэрэгжүүлэхээр хуульд заасан⁴⁸. Тайлант хугацаанд ЦЕГ болон ТББ-тай хамтран ЕБС-ийн сурагчдын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрт оруулан зааж байгаа боловч уг ажлуудын үр дүнг үнэлсэн мэдээлэл хангалтгүй байна.

Тодруулбал, ЦЕГ-аас Боловсролын байгууллагуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн хүрээнд ХХГХ-ийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл, тодорхой ажлуудыг хийхийг зөвлөдөг ч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээлэл нь цөөн зураг бүхий тайланг ирүүлдэг, үр дүн багатай, хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж чадахгүй байгааг албаны хүмүүс мэдэгдсэн⁴⁹.

Боловсрол шинжлэх ухааны яам (БШУЯ) нь хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд ЕБС-ийн Нийгэм судлал хичээлийн хөтөлбөрт хууль эрх зүйн мэдлэг олгох сэдвүүдийг, харин Эрүүл мэнд хичээлийн агуулгад "Хүний наймааны гэмт хэрэгт өртөх нь" сэдвийг тусган зааж байна.

Сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах (pornography), хүүхдийг цахим бэлгийн мөлжлөгөөр ашиглах (grooming) зэрэг гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдал нөлөөлсөн болохыг судлаачид онцлон тэмдэглэжээ⁵⁰. Харин секс аялал (sex tourism) хийгдэж буйг албан ёсоор тогтоогоогүй ч энэ чиглэлүүдээр нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийх, тэдгээрийн үр дүнд суурилсан урьдчилан сэргийлэх ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх шаардлага гарч байна⁵¹.

Дээр дурдсанаар Үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын биелэлт 93.9%-тай үнэлэгдсэн ч урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан адилгүй оролцоотой байна. Энэ нь хуулинд төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүргүүдийг тусгаж өгсөн ч үүргээ хэрэгжүүлэх боломж нь холбогдох салбарын журам, зохицуулалтын баримт бичигт тусгалаа бүрэн олоогүй холбоотой байж болох юм.

2.1.2. Олон улсын байгууллагууд

ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудын дийлэнх нь ОУБ-уудын санхүүжилт, дэмжлэгтэйгээр хийгдэж байна. Ялангуяа 2019-2021 оны хугацаанд урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байгууллагуудыг онцолбол ОУШХБ, Азийн сан, ДЗМОУБ-ууд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах асуудалд, ОУХБ албадан хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр голлон ажиллаж байна. Тэдгээр ОУБ-уудын урьдчилан сэргийлэх чиглэлд хэрэгжүүлж буй ажлуудыг авч үзвэл сургалт, сурталчилгаа, мэдээлэл

⁴⁸ УИХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=554>

⁴⁹ Азийн сан, ДЗМОУБ, Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаа: асуудал, шийдэл, хэлэлцүүлэг, Улаанбаатар, 2022.

⁵⁰ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021, 47-48 хуудас

⁵¹ Азийн сан, ДЗМОУБ, Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаа: асуудал, шийдэл, хэлэлцүүлэг, Улаанбаатар, 2022.



түгээх кампанит аянуудыг өрнүүлэх, ТББ-дад санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар үйл ажиллагааг нь дэмжих, чадавхжуулахад анхааран ажиллажээ. Мөн урьдчилан сэргийлэх чиглэлийн нэг чухал ажил нь судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх замаар бодлогын уялдаа холбоог хангах, эрх зүйн орчныг сайжруулахын тулд шийдвэр гаргалтад нөлөөлөх, техникийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхэд мөн анхаарч ажилласан байна. 2019-2021 оны хугацаанд ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд зургаан байгууллага идэвхтэй ажиллажээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн голлох ажлуудын тойм

№	Олон улсын байгууллага	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр	Голлох ажлууд
1	Азийн сан	"Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" (ДЗМОУБ хамтран)	ХХГХ-тэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх салбар дундын хамтарсан багийг байгуулах, чадавхжуулах, тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах зорилгоор албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах, хууль эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
2	Гүүд Нэйборс ОУТББ	Хүүхэд хамгааллын хөтөлбөр	Сургалт зохион байгуулах
3	Дэлхийн зөн Монгол ОУБ	"Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсоо" төсөл "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" (Азийн сантай хамтран)	Эрх зүйн орчныг сайжруулах, сургалт зохион байгуулах, судалгаа хийх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах
4	НҮБ-ын ОУШХБ	"Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол улсын хүчин чармайлыг бэхжүүлэх нь" төсөл (ГХУСА33 хамтран)	Сургалт, үндэсний аяныг зохион байгуулах, судалгаа хийх
5	НҮБ-ын Хүүхдийн сан	Хүүхэд хамгааллын хөтөлбөр	Сургалтыг зохион байгуулах, сурталчилгаа хийх
6	Хүүхдийг ивээх сан	"Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төсөл	Гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах, гар утасны аппликейшн

ОУБ-уудын урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудыг тоймлон харуулбал:

Азийн сан нь ашгийн бус, олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд Монгол Улсад төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран засаглал, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, байгаль орчныг хамгаалах, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд тус байгууллага нь "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" (2020-2024) төслийн хоёр зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд ХХГХ-т хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэхэд төр, нийгэм, хувийн хэвшлийн уялдаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах болон хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах хүрээнд албан хаагчдын чадавхыг

бэхжүүлэх ажлыг эхлүүлээд байна. 2021 онд ДЗМОУБ-тай хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: “Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн суурь судалгаа /гүйцэтгэгч байгууллага IRIM судалгааны хүрээлэн/, Бадамлянхуа сангийн санхүүжилтээр “ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааг /гүйцэтгэгч байгууллага Хүйсийн тэгш эрхийн төв/ зохион байгуулж, судалгааны тайлангуудыг олон нийтийн хүртээл болгосон. Мөн НҮБ-ын жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хүний наймааны эсрэг “Хөх зүрх аян-2021” хамтран ажилласан.

Гүүд Нэйборс ОУТББ нь хөгжлийн төлөөх ОУБ бөгөөд хүүхэд хамгааллын хөтөлбөрийг 52 салбараар дамжуулан хэрэгжүүлдэг. Уг байгууллага нь цахим болон танхимаар ХХГХ, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрөөс сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал, 2021 онд Баянзүрх дүүргийн ЕБ-ын 44, 53-р сургуулиуд, Хан-Уул дүүргийн ЕБ-ын 41, 34, 60-р сургуулиудын 11-15 насны нийт 1522 сурагчдад “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулсан.

Зураг 7. Хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье аян, ДЗМОУБ



Дэлхийн зөн Монгол ОУБ нь үндэсний хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хүүхэд хамгааллын тогтолцоо нь дахь оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын холбогдох яам, агентлаг, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутагтай хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд ХХГХ-тэй холбоотой дараах үйл ажиллагааг хийсэн байна. Тухайлбал, 2019-2020 онд Европын холбооны санхүүжилтээр “Хүүхдийн


эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё” төсөл, Азийн сантай хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” (2020-2024) төслийг хэрэгжүүлж байна. 2021 онд Азийн сантай хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: “Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн суурь судалгаа /гүйцэтгэгч байгууллага IRIM судалгааны хүрээлэн/, “Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааг /гүйцэтгэгч байгууллага Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ/ зохион байгуулсан. “Хүүхдийн хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” аяныг санаачлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ “Хөх зүрх- аян - 2021” нэгдэн ажилласан.

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) нь аюулгүй, хүнлэг, цэгцтэй дэмжих зорилготой дотоодын шилжилт хөдөлгөөний удирдлагыг бэхжүүлэх, хилийн нэгдсэн удирдлагыг сайжруулах, ХХГХ-тэй тэмцэх, гамшгийн бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, өөрийн хүсэлтээр эх орондоо эргэн ирэх, суурьшихыг дэмжих үндсэн чиглэлд ажиллаж байна. Тус байгууллага нь Засгийн Газрыг чанартай, бодит тоо мэдээллээр хангах, чадавхыг бэхжүүлэх, шилжилт хөдөлгөөнийг хөгжлийн




бодлогод тусгахад анхаарал хандуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд хүний наймааны шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлс, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр суурь судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтууд болон үндэсний аяныг зохион байгуулсан. Тодруулбал, сургалтад 880 гаруй албан хаагчид хамарч, ГХУСА33, Медиус ХХК-тай хамтран “Мөрөөдлийн шүхэр” аяныг 2021 онд амжилттай хэрэгжүүлсэн. Аяны хүрээнд есөн богино хэмжээний видео болон анимейшн, автобусны буудалд 13 төрлийн зурагт хуудас, хоёр стикер, өнгөт ханын зураг зуруулах ажил, 60 гаруй сэтгүүлчдэд ХХГХ-ийн талаар мэдээлэх цахим сургалт, мэдээлэл нь нийгмийн сүлжээнд 26 сая хүний хандалтыг авсан⁵². Мөн 2021 онд “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа”-ны тайланг олон нийтийн хүртээл болгосон.

Зураг 8. Мөрөөдлийн шүхэр аян, ОУШХБ



Зураг 9. Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь сургалт”-ыг ГХУСА33 болон НҮБ-ын Хүүхдийн сан 2021 онд хамтран зохион байгуулав.



НҮБ-ын Хүүхдийн сан нь Монголд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйлсэд үндсэн үйл ажиллагааг чиглүүлэн ажилладаг дэлхийн хэмжээний тэргүүлэгч байгууллага юм. Тайлант хугацаанд ХНХЯ, ГХУСА33, International Center for Missing and Exploited Children хамтран “Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь” сэдэвт чадавх бэхжүүлэх сургалтыг цагдаа, прокурор болон шүүхийн байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан. 2020 онд Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл, олон нийтийн газар, ажлын байран дахь дарамт, хүний наймаа, хүүхэд,

хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох зорилгоор #Хүчирхийллийг цэгцэлье уриаг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, элчин сайдын яамд, үндэсний болон улсын иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн компаниудад гаргасан. 2020 онд “Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгааг /ДХИС/ зохион байгуулжээ.

⁵² U.S Department, 2022 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан.

Зураг 10. “Чи ганцаараа биш” нөлөөллийн ажил



нийтийн сүлжээ, гар утасны аппликейшн, мессежээр дамжуулан өсвөр насны охидод зөвлөгөө, мэдээлэл хүргэх зэрэг ажлуудыг эхлүүлээд байна.

Байгууллагуудын нийтэд чиглэсэн мэдээлэл түгээх кампанит аян, сурталчилгааны ажлуудыг харвал 2019-2021 оны хугацаанд COVID-19 цар тахлын дэгдэлт, түүнээс үүдсэн нийтийн хөл хориотой холбоотойгоор цахимаар зохион байгуулах хэлбэр рүү зонхилон шилжсэн нь уг цаг хугацааны нэг онцлог байна. Урьдчилан сэргийлэх ажлын гол агуулгад сүүлийн жилүүдэд ХХГХ-ийн төрлүүд, түүний илэрч болох хэлбэрүүдийг таниулах чиглэлд урьдчилан сэргийлэх ажлуудыг илүү чиглүүлж байна гэж үзэж болохоор байгаа бөгөөд мэдээлэл түгээх олон хувилбарт аргуудыг (кино, шторк, нээлттэй өдөрлөг, тэтгэлэгт уралдаан, мэдээллийн хуудас, гар утасны аппликейшн гэх мэт) туршиж байгаа нь сайшаалтай байна. Гэвч мэдээлэл түгээх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг гаргаж, олон нийтийн хандлага, зан үйлд нөлөөлөхийн тулд тодорхой давтамжтай, дараалалтай, системтэй зохион байгуулахад анхаарах гэдэг дүгнэлт судалгааны тайлангуудад нийтлэг дурдагджээ.

2.1.3. Төрийн бус байгууллагууд

ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй зургаан байгууллага байна. Эдгээр байгууллагын дөрөв нь үйл ажиллагааны хувьд дагнан урьдчилан сэргийлэх ажилд төвлөрдөг бол үлдсэн байгууллагууд нь урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгааллын үйлчилгээг хослуулан явуулж байна. Байгууллагуудын туршлага, чадавхыг авч үзвэл хамгийн багадаа 10 жил, хамгийн ихдээ 23 орчим жил үйл ажиллагаа явуулсан харьцангуй цөөн, туршлага бүхий төрийн бус байгууллагуудтай (Хүснэгт 9).

Хүүхдийг ивээх сан нь хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох алсын хараатай, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрахыг зорилготой. Тус байгууллага нь хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, боловсрол, хүүхдийн ядуурал, эрүүл мэнд, хүмүүнлэгийн яаралтай тусламж зэрэг үндсэн чиглэлээр ажиллаж байна. 2021 оноос хэрэгжиж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хохирогч төвтэй, гэмтлийн дараах сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх 11 модуль бүхий сургалтын гарын авлага боловсруулах, Хөөрхөн зүрх ТББ хамтран зорилтот сургуулиудын 12-18 насны охид, хөвгүүдэд жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, “Чи ганцаараа биш” нөлөөллийн ажлыг цахим орчинд зохион байгуулах, олон



Хүснэгт 9. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд 2019-2021 онд хийгдсэн ажлуудын чиглэл

№	Төрийн бус байгууллага	Голлох ажлууд
1	Анбаунд Монгол ТББ	ХХГХ-т өртөх эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг илрүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, үндэсний аянг зохион байгуулах, мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах
2	Хөөрхөн зүрх ТББ	Үндэсний аян зохион байгуулах, сургалт зохион байгуулах, анимейшн хийх, гар утасны аппликейшныг хөгжүүлэх
3	Хүйсийн тэгш эрхийн төв	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, компани ажил зохион байгуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, судалгаа хийх, зөвлөгөө өгөх, баримт кино, контентыг бэлтгэх
4	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ	Эрх зүйн орчныг шинэчлэх
5	Хүний эрхийн үндэсний комисс	Үндэсний аян зохион байгуулах, брошюр, гарын авлага боловсруулах, түгээх
6	Экпат Монгол Үндэсний сүлжээ	Үндэсний аяныг санаачлан хэрэгжүүлэх, сургалтуудыг зохион байгуулах

Эдгээр байгууллагуудын хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг чиглэлээр нь багцалж авч үзвэл дараах үндсэн чиглэлийн ажлууд нийтлэг хийгдэж байна:

- Эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг илрүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх,
- Олон нийтэд чиглэсэн мэдээлэл түгээх, үндэсний арга хэмжээ, аян зохион байгуулах,
- Контентууд боловсруулах, брошюр, гарын авлага боловсруулж, түгээх, баримтат кино нэвтрүүлэг бэлтгэх анимейшн хийх, гар утасны аппликейшн хөгжүүлэх,
- Олон нийт, зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, төрийн байгууллагын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх,
- Олон улсын туршлага судлах, судалгаа хийх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Төрийн бус байгууллагуудын 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн ажлуудыг тоймлон харуулбал:

Анбаунд Монгол ТББ нь урьдчилан сэргийлэх чиглэлд илүү олон нийт рүү чиглэсэн урт болон богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сайн дурын сургагч багш нарын оролцоотойгоор олон нийтэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулах, мөн дотоодын мэргэжилтнүүдэд гаднын улсаас сургагч багш нарыг урьж, сургалт чадавхжуулах ажлыг зохион байгуулдгаараа онцлогтой. Анбаунд ТББ нь хил дээр дамжин өнгөрч буй зорчигчдыг ажиглан, тодорхой аргачлалын дагуу ХХГХ-т өртөж байж болзошгүй иргэдийг илрүүлэн цагдаа, хамгаалах байр зэрэг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилдаг. Тодруулбал, 2018 оноос хойш хэрэгжүүлсэн “Дамжин өнгөрөх ажиглалт” төслийн хүрээнд хил хамгаалах албан хаагчдад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх анхан шатны сургалтуудыг зохион байгуулж, ХХГХ-т өртөх эрсдэлтэй 205 эмэгтэйг тогтоон, 38 охид, эмэгтэйчүүдэд ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах талаар зөвлөгөө өгснөөс 24 эмэгтэй гадаад улс руу гарахаас татгалзсан тул гэр бүлд нь аюулгүй буцаасан⁵³. Энэ төсөл нь эрсдэлт бүлгийн

⁵³ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021, 32 хуудас.

охидыг илрүүлэн зөвлөгөө өгч, гадагшаа гарч эрсдэлд өртөхөөс сэргийлсэн нь сайн туршлагад тооцогдохуйц ажлууд байна. Мөн 2021 онд ЕБС-ийн 6-8-р ангийн сурагчдад “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, цахим орчинд өөрийгөө хамгаалах” сургалтыг зохион байгуулсан. ДЗМОУБ-тай хамтран Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд ХХГХ-т өртөж болзошгүй хүүхдийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хамтарч ажиллаж байна.

Хөөрхөн зүрх ТББ нь урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хүүхэд, өсвөр насны охид, хөвгүүдийг жендэрт суурилсан хүчирхийллээс үүдэлтэй аливаа болзошгүй бэрхшээлээс урьдчилан сэргийлэхэд ухуулан сурталчилдаг. Тус хөтөлбөрийн хүрээнд “Цахим орчин дахь ухаалаг хэрэглээ” сургалт, нөлөөллийн ажил, “Хүчирхэг охид-Хүчирхэг Улс” хөтөлбөр, “Тавдугаар сар-Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” үндэсний хэмжээний кампанит ажлуудыг зохион байгуулсан. Тухайлбал, 2019 онд “Хүчирхэг охид” гар утасны аппликейшныг 2,200 хүүхэд татсан, “Тэрбумаараа тэмцье 2020-Бидний дуу хоолой”, “Тэрбумаараа тэмцье-2021” хөдөлгөөнийг зохион байгуулсан. 2020-2021 онд “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё” төслийг хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой уг төслийг ДЗМОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн.

Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ) ТББ нь ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд шууд туслалцаа үзүүлэх, эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх, хилийн чанадаас эгүүлэн авчрах, хүний эрх, хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомжийн талаарх мэдээллийг өгөх, эрх зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, хуулийн байгууллагад хандсан хохирогч нарын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг мэргэшүүлэн ажиллуулдаг ба дээрх хугацаанд 59 хохирогчтой 29 хэрэгт өмгөөллийн туслалцаа үзүүлж ажилласан байна. Тайлант хугацаанд ХХГХ-ийн хохирогч болсон 121 хохирогчид туслалцаа үзүүлсний 28% нь насанд хүрээгүй охид, 72% нь эмэгтэйчүүд байсан ба тэдний 17 Малайз уулсаас, нэг хохирогчийг Филиппин улсаас эх орондоо аюулгүйгээр эгүүлэн авчирсан ба тус төвд хандсан бүх үйлчлүүлэгчдийг эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулан ажилласан. ХХГХ-ийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сэрэмжлүүлэх зорилгоор даван туулагчийн түүхээр баримтат кино, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэх, цахим кампанит ажил өрнүүлэх, сурталчилгааны материалуудыг олон төрлөөр бэлтгэж хэвлүүлэх, түгээх, сургалтуудыг зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэсэн.

Тодруулбал, найз залуугийнхаа үгэнд итгэн гадаад улс руу явсан ч 10 гаруй жил бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон нэгэн бүсгүйн /даван туулагч/ бодит түүхээр баримтат киног бүтээжээ. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор ХНХЯ, БНСУ-ын Гэр бүл, жендэрийн тэгш эрхийн яамтай хамтран 2019 оноос хэрэгжүүлж буй төслийн хүрээнд гурван цуврал цахим хичээлийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Жендэрийн эрх тэгш байдал, ХХГХ, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сургалтуудыг мэргэжлийн болон эрсдэлтэй бүлгүүд болон олон нийтэд зохион байгуулсан. Мөн 2020 оноос “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд ХХГХ-ийн хохирогч хүүхдийг олж илрүүлэх, тэдэнд цогц үйлчилгээ үзүүлэх төрийн болон иргэний нийгмийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлыг хийж байна. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийн



хүрээнд олон нийт, зорилтот бүлэгт ХХГХ, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх боловсрол олгох сургалтыг 357 эцэг эх, асран хамгаалагч, 477 багш, нийгмийн ажилтан, 239 хууль сахиулах байгууллагын ажилтнууд, 2755 оюутан, сурагч, 50 зочид буудал, саун массажны газрын ажилтнууд, 23 сэтгүүлч, 663 охид, эмэгтэйчүүдэд зориулан зохион байгуулав. Түүнчлэн 2021 онд Хурд агентлагийн Найм арван нэг тоймчийн хөтөлбөрөөр “Хүн худалдаалах гэмт хэрэг” сэдвээр бэлтгэсэн. 2021 онд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Экпат Монгол Үндэсний сүлжээ нь урьдчилан сэргийлэх ажил болох сурталчилгаа, сургалтуудыг зохион байгуулахын зэрэгцээ бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд туслалцаа үзүүлдэг олон улсын байгууллагын харьяа байгууллага юм. Тайлант хугацаанд тус байгууллага нь хүний наймааны эсрэг “Хөөрхөн зүрхний аян-2021”-ыг ОУШХБ, ТББ-уудтай хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Мөн Залуучуудын хөгжлийн хөтөлбөрөөс хүний наймааны эсрэг хоёр цуврал видеог бэлтгэн олон нийтэд хүргэсэн. “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд “Гэрээр айлчлагч сайн дурын ажилтан” хөтөлбөрийг ГБХЗХГ-тай хамтран хэрэгжүүлж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) нь эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийг арилгах зорилгоор эрх зүйн шинэчлэлийг хийх, чадавх бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулах, “Итгэлтэй утас”-ны зөвлөгөө өгөх чиглэлээр түлхүү үйл ажиллагаа чиглүүлж ажиллаж байна. Тайлант хугацаанд ХХГХ-ийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор анимэйшн, брошюр, гарын авлага боловсруулж, түгээсэн.


Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ нь хүүхэд хамгааллын чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллахдаа бодлогын орчинд нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2019-2021 оны хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл шинэчлэх ажилд оролцож байна.

ТББ-уудын хувьд тодорхой хугацааны төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж байгаа хэдий ч эдгээр байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн арга барилыг харгалзвал илүү олон талын туршлагыг хуримтлуулж чадсан байгаа тул амжилттай сайн хэрэгжсэн төсөл хөтөлбөрийг давтан хэрэгжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах замаар тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлагатай.

2.2. Хохирогч хамгаалал

Монгол Улсад өнөөдрийн байдлаар ХХГХ-ийн хохирогчид хамгааллын туслалцаа үзүүлж буй бүтцийг Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгааны тайланд туссан дараах зураг нэгдсэн байдлаар харуулж байна. Уг схем нь хууль эрх зүйн заалт болон үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын практик туршлагуудад тулгуурлан боловсруулагджээ.

Зураг 11. Монгол Улсад хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй механизмын зураглал



Эх сурвалж: Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн сүүрх судалгаа

Гэвч уг зураглал нь зөвхөн одоо явж буй ерөнхий бүтцийг л илэрхийлэх бөгөөд үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой судалгааны үр дүнгүүдийг харгалзвал хохирогч хамгааллын үйлчилгээний чадавх илүү ТББ-ын чадавх дээр суурилсан гэдэг дүгнэлтэд хүрч байна. Дараах гол асуудлууд хохирогч хамгааллын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг илтгэж байна.

Хэдийгээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай⁵⁴ хуулийн 12-р зүйлд ХХГХ-ийн хохирогчид таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээ⁵⁵-г үзүүлэхээр заасан хэдий ч (1) “хохирогч”-ийг авч үзэх тодорхойлолт холбогдох хуулиудад зөрүүтэй (2) анхан шатны үйлчилгээг хэрхэн үзүүлэх зохицуулалт тодорхойгүй (3) хуульд заасан нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохих журмууд батлагдан гараагүй (4) үйлчилгээний санхүүжилтийн тогтмол байдал шийдэгдээгүй зэрэг асуудлууд нь хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлэх төрийн механизм хараахан бүрдээгүй, энэ орон зайг ТББ-уудын хүчин чармайлт нөхөж байгааг харуулж байна.

⁵⁴ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №7, УБ., 2012 он,

55 Эрүүл мэндийн, Сэтгэцийн, Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа, гадаад улсад Монгол Улсын консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтах бичиг баримт олгох, эх оронд нь буцаан авчрах



Тухайлбал, Талита-Ази ТББ нь удаан хугацаагаар хамгаалах байр ажиллуулахын зэрэгцээ сэтгэл заслын цогц үйлчилгээ, ХТЭТ ТББ нь хохирогчдыг гадаад улс орноос эгүүлэн авчрах, түр хамгаалах байранд байрлуулах, нийгмийн ажлын цогц үйлчилгээ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Иргэдэд туслах хүний эрхийн төв нь хууль зүйн туслалцаа, зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр нөхцөл байдлыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Хохирогчийг тодорхойлж буй байдал: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарим хуулиудад заасан “хохирогч”-ийн тодорхойлолт нь ялгаатай байдлаар тодорхойлогдсоныг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 10. Хохирогчийн талаарх хуулийн тодорхойлолтууд

Холбогдох хуулиуд	Тодорхойлолтууд
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	3.1.2. Хохирогч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ.
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	4.1.1. “Гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	5.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Тодруулбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг илүү өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд хохирогч нь заавал хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шууд хандан хохирогчоор бүртгэгдэж, шаардлагатай хамгаалал, тусламж үйлчилгээ авч болохоор заасан байна⁵⁶.

Гэвч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон хүнийг хохирогч гэж үзэхээр заасан байгаа нь хуулийн байгууллагад хандахыг хүсэхгүй байгаа хохирогч, хэдий эрсдэл өндөр байсан ч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авч чадахгүйд хүрэх асуудал байна.

Хохирогч хамгааллын үйлчилгээ: ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, туслалцаа үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дараах стандартууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна⁵⁷.


- “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS6418:2013) стандарт нь ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилготой. Уг стандартад ХХГХ-ийн хохирогчийг

⁵⁶ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, УБ, 2022

⁵⁷ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, УБ, 2021

тогтоох маягт, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээний үе шатуудад тавигдах шаардлагыг тогтоосон. Уг стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудад хамаарах зохицуулалттай ба хохирогчийн нөхцөл байдлаас хамааран дараах зургаан төрлийн үйлчилгээнд хамрагдахаар тусгасан.

Зураг 12. ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээний төрөл



Гэвч энэ стандартыг зөвхөн ТББ-ын үйл ажиллагаа, тэднээс үзүүлж буй үйлчилгээнд баримтлахыг шаардсанаар төрийн байгууллагын үйлчилгээнд хамааралгүй болж, өргөн хүрээнд ашиглах боломжийг хязгаарласан шинжтэй байна. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагад хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд баримтлах стандарт огт байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

- “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6040:2019) стандарт нь хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх зорилготой.

Эдгээрээс гадна “Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх”, “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах”, “Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам”-ыг батлан хэрэгжүүлэхээр хуульд заасан боловч тус журам нь уг тайланг боловсруулах хугацаанд боловсруулагдан гараагүй байв. Энэ нь ХХГХ-ийн хохирогч хууль зүйн туслалцаа авах болон аюулгүй байдлаа хамгаалуулах үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна.

Тухайлбал, 2021 онд хийгдсэн Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны хүрээнд шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хавтаст хэргүүдэд шинжилгээ хийхэд нийт 14 хохирогчоос зөвхөн нэг л хүн өмгөөлөгч авсан бол үлдсэн 13 хохирогч нь төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөллийн үйлчилгээ авч чадаагүй гэсэн байв⁵⁸. Мөн Хүн худалдаалах түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайланд” 10 хохирогчтой дөрвөн эрүүгийн хавтаст хэрэгтэй танилцахад найман хохирогч нь огт өмгөөлөгчгүйгээр Эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагаа (ЭХХША)-нд оролцож, хоёр хохирогч нь анхан болон давж заалдах шатны шүүх хуралд л өмгөөлөгчтэй оролцсон байна.

⁵⁸ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, УБ.,2022



Төр ийнхүү төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг орхигдуулсныг үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд нөхөн, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд мэргэшсэн өмгөөлөгч хөлслөх байдлаар ажиллаж байна. Эдгээр байгууллагуудаас жишээ дурдахад Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ-аас 2017-2020 онд 10 орчим хохирогчид өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлсний гурав нь хүүхэд байсан. Мөн ХТЭТ ТББ нь ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд хүний эрх, хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомжийн талаарх мэдээллийг өгөх, эрх зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, хуулийн байгууллагад хандсан хохирогч нарын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг ажиллуулж байна⁵⁹.

Харин УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан нь дээрх нөхцөл байдлыг шийдвэрлэх нэг алхам болж, улмаар ХХГХ-ийн хохирогч, төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч болох эрх зүйн орчин бүрдсэн байна. Энэ талаар тус тайлангийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны хэсэгт дэлгэрэнгүй дурдав.

Хохирогч хүүхдийг хамгаалж буй байдал: Прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр 2021 онд бүртгэгдсэн хүн худалдаалах найман гэмт хэрэгт 10, бэлгийн мөлжлөгийн гурван гэмт хэрэгт хоёр, биеэ үнэлэхийг зохион байгуулах есөн гэмт хэрэгт нэг, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 19 гэмт хэрэгт 16, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах хоёр гэмт хэрэгт зургаан насанд хүрээгүй хүн хохирогчоор тогтоогдсон байна. Гэтэл 2020 онд эдгээр гэмт хэрэгт 17 насанд хүрээгүй хүн хохирогчоор тогтоогдсон бол 2021 онд энэ тоо 35 болж нэмэгдсэн байна⁶⁰.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд⁶¹ хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд⁶² хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг тус тус хуульчилсан. Гэтэл эдгээр хууль тогтоомжид ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдийг хэрхэн илрүүлэх, хамгаалах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг яаж үзүүлэх талаарх тусгайлсан зохицуулалт хангалтгүй, салбар хуулиудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

ХХГХ-ийн хохирогч хүүхдүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэгчид, зуучлагч эсвэл хүлээн авагчдын зүгээс ирэх бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон улмаар тарчлаах үйлдлийн хохирогч болсон байдал нь дээрх төрлийн гэмт хэргийн хохирогчдод тусгайлан хамгаалуулах, урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах онцгой шаардлага тулгардаг. Иймд ХХГХ-ийн хохирогч хүүхдүүдэд хохирогч хамгааллын тусгай зохицуулалтыг бий болгох нэн шаардлагатай байхын зэрэгцээ үйлчилгээ үзүүлж буй төрийн болон ТББ-ын албан хаагч, мэргэжилтнүүд тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн эрхийн мэдрэмжтэй байх шаардлагатай.

Одоогийн байдлаар хүүхэд ХХГХ-т өртсөн тохиолдолд хүлээн авах боломжтой хамгаалах байр Талита Ази болон ХТЭТ ТББ-уудад байрлаж байна. Эдгээр байрыг хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн 2021 онд Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд тохижуулсан бөгөөд 2022 оны байдлаар давхардаагүй тоогоор нийт 23 хүүхдийг хамгаалах байруудад хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн байна. Гэсэн хэдий ч хамгаалах байрнаас гарсан бага насны хүүхдийг урт хугацаанд нь хамгаалах, үйлчилгээ үзүүлэх асуудал шийдэгдээгүй хэвээр байна.

⁵⁹ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021. Хуу 46

⁶⁰ Азийн сан, ХТЭТ ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2022

⁶¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, Дугаар 07

⁶² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, Дугаар 05

Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгааны тайланд⁶³ дурдсанаар хүүхдийн эсрэг үйлдэж буй бэлгийн мөлжлөг, ХХГХ өсөх хандлагатай байна. Ялангуяа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн байх тохиолдол сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Тиймээс бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчдод руу чиглэсэн урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ чухлаас гадна сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг хөгжүүлэх, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна. Мөн хохирогч хүүхдийг таньж илрүүлэх чиглэлээр мэргэжлийн бүлэгт чиглэсэн сургалтын хэрэгцээ өндөр байгааг тайлангуудад онцолсон байна⁶⁴.

Үйлчилгээний санхүүжилт: Хохирогч хамгааллын үйлчилгээний дийлэнх ачааллыг ТББ-ууд өөрсдийн үйл ажиллагаа, санаачилгадаа тулгуурлан авч явж байгаа талаар өмнө дурдсан. Тухайлбал, Талита-Ази ТББ нь хамгаалах байранд ХХГХ-ийн хохирогчийг урт хугацаагаар байрлуулдаг ба дээд тал нь нэг хохирогчийг гурван жилийн хугацаатай байрлуулж байсан туршлага байна. Одоогийн нөхцөлд дээр дурдсан үйлчилгээг ОУБ-ын дэмжлэгтэйгээр түлхүү санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Тэгвэл энэ нөхцөлд үүсэж болох хамгийн том эрсдэл нь ТББ-ын санхүүжилтийн тогтвортой байдлаас шалтгаалан үйлчилгээ тасалдах явдал байна.

Төрөөс хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж буй туршлага одоогоор байхгүйн зэрэгцээ энэ төрлийн үйлчилгээнд тусгайлсан төсөв тавигдсан, зарцуулагдсан туршлага өмнө байгаагүй. Харин 2019 онд Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах⁶⁵ зорилгоор ХЗДХЯ-аас ХТЭТ ТББ-д “Хохирогч хамгааллын үйлчилгээг тогтмолжуулах” зөвлөх ажил үйлчилгээний төслийн хүрээнд 20⁶⁶ сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ нь ХХГХ-т өртсөн 15 хохирогчийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдсан сайн туршлага байна. Мөн хамгаалах байр ажиллуулж, сэтгэл зүй-нийгмийн, эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудад 2021 онд Засгийн газраас 30 сая төгрөгийн санхүүжилт өгчээ⁶⁷.

Хохирогчийг нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээг үзүүлэхэд урт хугацаа шаардагддаг онцлогтой тул энэ тохиолдолд дан ганц ТББ-ууд өөрсдийн үйл ажиллагаа, санхүүгийн чадавхаар хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж явах нь үйлчилгээний тогтвортой байдал талаас хамгийн тулгамдсан асуудал байна.

Хохирогч хамгааллын асуудлаар хууль эрх зүйн орчинд олон хийдэл байхаас гадна зохицуулагдаагүй үлдсэн асуудлууд байна. Тухайлбал, ХХГХ-ийн хохирогчийг хамгаалан байрлуулах анхан шатны үйлчилгээг зөвхөн ТББ-ууд үзүүлж, бусад шаардлагатай сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцааг тодорхой хугацаатай төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохицуулж байна. Үүнээс үзэхэд хохирогчид үйлчилгээ үзүүлэх механизмыг онцгойлон авч үзэх, ингэхдээ хохирогчдод туслалцаа үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг судлах, тэдгээрийн цаашдын тогтвортой байдлыг хангах, улмаар улсын төсвөөс хохирогч хамгааллын анхан болон нөхөн сэргээх үйлчилгээнд зориулж төсөв хуваарилдаг болох хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

⁶³ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021

⁶⁴ Мөн тэнд

⁶⁵ АНУ-ын Хүний наймааны илтгэл 2020-д Монгол Улсын Засгийн газар Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 509 сая төгрөг зарцуулсан гэжээ.

⁶⁶ ХЗДХЯ, “Эс Ай Си Эй” ХХК “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” тайлан, 2019

⁶⁷ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан



2.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд ХХГХ-тэй тэмцэх чиг үүргийг нэг алба хаагч хариуцан ажилладаг байсан бол “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар⁶⁸ ХХГХ-тэй тэмцэх тасаг таван хүний орон тоотой байгуулагдан ажиллаж байна. Уг нэгж нь улсын хэмжээнд ХХГХ-ийн нөхцөл байдлыг тодорхойлж, энэ төрлийн гэмт хэрэг болон мэдээллийн урсгалд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, таслан зогсоох үндсэн чиг үүргийг хүлээж байна. Түүнчлэн ЦЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/316 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны бүтцэд Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг шинээр байгуулан ажиллуулж байгаа нь ХХГХ-ийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд дэмжлэг үзүүлэх боломжтой өөр нэг бүтэц байна. Мөн УЕПГ нь 2020 онд “Хүн худалдаалах болон бусад төстэй гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийг дагнан хариуцах прокурорыг томилон ажиллуулах” чиглэлийг харьяа прокурорын газруудад өгч, улсын хэмжээнд 49 прокурор энэ төрлийн хэрэгт дагнан хяналт тавин ажиллаж байна.

Өмнөх бүлэгт дурдсанчлан 2019-2021 оны хугацаанд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ-ээр нийт 31 хэрэг ЦЕГ-т бүртгэгдсэн. Эдгээр тохиолдлууд нь бүхэлдээ бэлгийн мөлжлөгийн тохиолдол байсан. Өөрөөр хэлбэл бэлгийн мөлжлөгийн хэлбэр Монгол Улсад зонхилон үйлдэгдэж байгаа мэт боловч Монгол Улсын эрх зүйн орчин дахь ХХГХ-ийг авч үзэх тодорхойлолтын зөрүүтэйгээс ХХГХ-ийн шинжтэй тохиолдлууд өөр бусад бага ялтай гэмт хэргээр зүйлчлэгдэх бүрэн боломжтой байгааг судалгааны тайлангуудад нийтлэг дурдсан байна.

Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд мөн ХХГХ-ийг хуульчлахдаа бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтнийг авах зэрэг үйлдлийг ХХГХ-т тооцох, хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байх нь хамааралгүй байхаар зохицуулсан боловч ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь хуулийн зүйл, заалтын давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ХХГХ-ийг зүйлчилсэн хэдий ч мөн хуулийн дараах зүйл заалтын агуулга, шинж нь ХХГХ-ийн шинжийг агуулсан байна. Үүнд:

- 12.3 дугаар зүйлд Бэлгийн мөлжлөг,
- 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах,
- 13.13 дугаар зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйлд Хүүхдээр гуйлга гуйлгах,
- 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдах,
- 16.8 дугаар зүйлд Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах,
- 16.9 дугаар зүйлд Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах,
- 16.10 дугаар зүйлд Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх

⁶⁸ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан

Эрх зүйн орчны дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор хийгдсэн бүхий л судалгааны тайлангуудад ХХГХ-ийн гаралт, статистик тоо баримтыг баримжаалахын тулд Эрүүгийн хуулийн дээрх бүх гэмт хэргүүдийн нөхцөл байдлыг давхар авч үзэж судалсаар байна. Энэ нь одоогийн нөхцөлд ХХГХ-ийн тоо баримтыг бүрэн дүүрэн гаргах боломжгүйг харуулж байна.

Гэмт хэргийн гаралтын өсөлт бууралтыг харвал Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ХХГХ-ийн гаралт буурсан үзүүлэлттэй мэт харагдаж байгаа боловч энэ нь цар тахлын нөхцөл байдлын улмаас улсын хилийн хязгаарлалтаас гадна дотоодын зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай шууд холбоотой. Тоо буурсныг гэмт хэргийн гаралт багассан гэж тайлбарлахаас илүүтэй далд хэлбэрт шилжиж, арга барил өөрчлөгдөж байж болзошгүй гэж үзэж байна⁶⁹.

Мөн ХХГХ-тэй ижил төстэй зарим гэмт хэргийн гаралт эсрэгээр өссөн байгаа нь дээрх дүгнэлтэд хүргэж буй өөр нэг үндэслэл юм. Ялангуяа хүүхдэд садар самууныг сурталчлах, түүнд татан оруулах замаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болгох, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдал сүүлийн дөрвөн жилийн хугацаанд өссөн байна⁷⁰.

Зураг 13. 2020, 2021 онд бүртгэгдсэн зарим гэмт хэрэг хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүний тоон харьцуулалт



Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үйлдэхдээ 18 насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол ХХГХ-т хамаарна гэж тайлбарласан. Прокурорын байгууллагаас авсан дээрх тайлант хугацааны тоон мэдээлэлд энэ гэмт хэрэгт насанд хүрээгүй нэг хүн хохирогчоор тогтоогдсон талаар мэдээлсэн байна. Өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүний эсрэг биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдсэн гэдгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, мөрдөх эрх бүхий байгууллага мэдсэн боловч ХХГХ-т тооцож шийдвэрлээгүй нь гэмт хэргийн зүйл заалтын тодорхойгүй байдлаас үүдэлтэй нөхцөл байдал юм.

⁶⁹ Азийн сан, ХТЭТ ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ.,2022

⁷⁰ Мөн тэнд



Дараах үндэслэлүүд нь ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг Эрүүгийн хуульд давхардуулан хуульчилсан гэж үзэхэд хүргэж байна⁷¹. Үүнд:

Нэгдүгээрт, Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 12.3.4 дэх хэсэгт “энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж, ашиг олох зорилгоор бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн” бол оногдуулах ялыг хүндрүүлж оногдуулахаар заасан. Гэвч мөн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийг ашиг олох зорилгоор бэлгийн мөлжлөгт өртүүлсэн нь Эрүүгийн хуулийн 12.3 эсхүл 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн аль нь болох талаар өрсөлдүүлсэн хэм хэмжээг бий болгосон нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд саад учруулж байна.

Хоёрдугаарт, Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохоор заасан. Гэвч тус заалтын зүйлчлэлийн агуулга нь⁷² Эрүүгийн хуулийн 13.1 ХХГХ-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжтэй давхцаж байна.

Гуравдугаарт, Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн сайшаалтай хэдий ч дээр дурдсан заалтууд нь мөн л ХХГХ-ийн шинжтэй давхардаж байгаа юм. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн бол ямар аргаар хэрхэн үйлдсэн эсэхийг үл харгалзаж ХХГХ гэж үзэхээр заасан ч хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүлэгт хамаарах гэмт хэргүүдийн үндсэн шинж нь ХХГХ-ийн шинжтэй давхцаж буйгаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсэх буюу аль зүйл заалтаар хэргийг шийдвэрлэх эсэхийг шийдэхэд хүндрэл тулгарахаар байна.

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтнийг авсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл буюу ХХГХ-ийн агуулга нь “...хүний эд, эрхтнийг авах...” үйлдлийг мөн хамарсан байна.

Ийнхүү ХХГХ-ийн төрөл хэлбэр тус бүрийг бие даасан гэмт хэрэг гэж тооцох нь энэ төрлийн гэмт хэргийг бусад гэмт хэргээр зүйлчилж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх явцад нийтлэг тохиолдолд гэмт хэрэг үйлдэгчийн субъектив санаа, сэдлийг тогтоож чадаагүй нөхцөлд түүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтаар буюу бага ялтай зүйл ангиар шийдвэрлэх зарчим үйлчилдэг билээ.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн нөхцөл байдал: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдлыг илтгэх өөр нэг чухал үр дүн нь Цагдаагийн байгууллагад 2017-2021 онд бүртгэгдсэн

⁷¹ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ., 2021

⁷² “хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн”

гэмт хэргийн статистик, прокурор болон шүүхийн статистик мэдээллийн хооронд бүртгэгдсэн гэмт хэрэг болон шийдвэрлэсэн хэргийн хоорондын зөрүү хэт хол байгаа нь илэрч буй хэргүүд хангалттай шийдвэрлэгдэхгүй байх гэдэг эргэлзээг дагуулж байна.

Тодруулбал, 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, гурван хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь нийт гэмт хэргийн 58% нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатанд дуусгавар болж байгааг харуулж байна. Харин шүүхэд 53 хэргийг шилжүүлснээс 17 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна.

2017-2021 онд ХХГХ нийт 76 бүртгэгдэж, үүнээс 43 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, гурван хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна. Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 12 хэргийг шилжүүлж, үүнээс дөрвөн хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл ХХГХ гэж бүртгэгдсэн тохиолдлуудын 56.5% нь ХХГХ биш гэж тооцогдож байна.

2017-2021 онд бэлгийн мөлжлөгийн 39 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс 22 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, нэг хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна. Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 11 хэргийг шилжүүлж, үүнээс хоёр хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Бэлгийн мөлжлөгийн шинжтэй тохиолдлын 59% нь буцаагдаж байна.

2017-2021 онд албадан хөдөлмөрлүүлэх дөрвөн гэмт хэрэг бүртгэгдсэн ч дөрвүүлээ хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсад албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэсэн нэг ч хэрэг байхгүй байна.


2017-2021 онд хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах нэг гэмт хэрэг бүртгэгдсэн ч хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэсэн нэг ч хэрэг байхгүй байна⁷³.

2017-2021 онд хүүхдээр гуйлга гуйлгах нэг, хүүхэд худалдах хоёр гэмт хэрэг бүртгэгдсэн ч хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

2017-2021 онд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг 26 бүртгэгдэж, 23 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, хоёр хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, ажиллагаанд нэг хэрэг байна.

Шүүхээр шийдвэрлэсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн шийдвэрлэлтийг тусад нь авч үзвэл ХХГХ дөрөв, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хоёр, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг гурав, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг зургаа, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг хоёр тус тус эцэслэн шийдвэрлэгдсэн байна⁷⁴.

Зураг 14. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн инфографик⁷⁵



⁷³ 2017 оноос өмнө нь энэ гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж байсан тохиолдол байхгүй.

⁷⁴ Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагаас авсан мэдээ

⁷⁵ Азийн сан, ХТЭТ ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2022



Шүүхэд шилжүүлсэн хэргүүдийн дийлэнх нь шийдвэрлэгдэж чадахгүй байгаа нь тухайн гэмт хэргийн онцлогоос гадна 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-ийн талаар холбогдох албан хаагчдын ойлголт харилцан адилгүйгээс ХХГХ-ийг өөр зүйл ангиар зүйлчлэх зэргээр гэмт хэрэгтнүүдэд хөнгөн ял оноох эрсдэлүүд байгаа талаар АНУ-ын Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай 2019 оны тайланд дурдсан байна. Шүүхийн ажилтнуудын Эрүүгийн хуулийн ХХГХ-тэй холбоотой тодорхой заалтуудын талаарх ерөнхий мэдлэг, ойлголт дутмаг байдгаас зарим хэргүүдэд хөнгөн ял шийтгэл оногдуулахад хүргэж байна.

Шийдвэрлэгдсэн хэргүүдэд оноож буй ял шийтгэл: Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлд ХХГХ үйлдсэн этгээдэд шүүхээс гэмт хэргийн шинж, хөнгөрүүлэх болон хүндрүүлж үзэх нөхцөл байдал зэргийг харгалзан 2-20 хүртэл жилийн хорих ял эсхүл бүх насаар нь хорих ял оноохоор заасан. Эдгээр ял шийтгэл нь хангалттай чанга бөгөөд бэлгийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ-ийн ял нь хүчиндэх гэх мэт бусад хүнд гэмт хэрэгт оногдуулдаг ялтай дүйцэхүйц хүнд заалт болсон⁷⁶.

Гэвч төстэй зарим гэмт хэргийн тухайд оногдуулах ял шийтгэл харилцан адилгүй буюу ХХГХ-ээс бага ял, эрүүгийн хариуцлагатай байна. Иймд ихэнх тохиолдолд гэмт хэрэгтэн зохих ял шийтгэл амсахгүй байх, хохирогчийг өөрийг нь гэмт хэрэгтэн болгох, мөн зарим тохиолдолд ХХГХ үйлдсэн этгээдэд хөнгөн ял оногдуулах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны явцад хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох боломж хязгаарлагдмал тул аль болох хүнд ялтай зүйл хэсгээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгах талаар мөрдөгч, прокурор аль аль нь анхаарах нь зүйн хэрэг юм.

Хэрэг хянан шийдвэрлэгдэж буй хугацаа: Монгол Улсад ХХГХ-ээр үүсгэсэн хэргийг шийдвэрлэхэд хэдий хугацааг зарцуулж байгааг хуулийн заалт болон шийдвэрлэгдсэн хавтаст хэргийн дунджаар тооцоход ойролцоогоор анхан шатны шүүх прокуророос хүлээж авснаас хойш шийдвэрлэх хүртэл 1-10 сарын хугацаа, анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл 3-9 сарын хугацааг тус тус зарцуулсан байна. Шүүхийн нийт хугацааг харвал 4-19 сарын хугацаа зарцуулжээ⁷⁷. Мэдээж энэ хугацаа нь тухайн хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээд тогтоогдсон эсэх, ялагдагчаар татагдсан эсэх, холбогдогч болон хохирогчийн тоо, тухайн гэмт хэрэг хэдий хэр хугацаанд үргэлжилсэн зэргээс шалтгаалж байгаа хэдий ч ихэнх тохиолдолд энэ төрлийн хэргийн шийдвэрлэх процесс хэт удаан үргэлжилдэг нь хэрэг үнэн бодитой шийдэгдэх, хохирогч мөн хэргийг шийдэгдэх хүртэл тэмцэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байгааг тайлангуудад нийтлэг дурдсан байна. Бодитой мөрдөн шалгах ажиллагаа явагдсан кейсүүдийн шийдвэрлэгдсэн хугацааг харьцуулан авч үзвэл хамгийн ихдээ **2 жил 5 сар 14 хоногт** шийдвэрлэгдсэн кейс байна.

Харин ЭХХШТХ-д зааснаар прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийг шүүх хүлээж аваад 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх⁷⁸ (шаардлагатай бол 30 хүртэл хоногоор сунгана), ийм шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх⁷⁹ хуулийн зохицуулалттай. Өөрөөр хэлбэл прокуророос шүүх рүү шилжүүлсэн хэргийг хүлээн авч хянан шийдвэрлэх хүртэл 34-64 хоног зарцуулах боломжтой байгаа хэдий ч шүүх хуралдааны үед гарсан хүсэлтүүдийг шийдвэрлэх, тодорхой шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах зэрэг шалтгаанаар үүнээс ч их хугацаа зарцуулах тохиолдол байсаар байна.

⁷⁶ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

⁷⁷ Азийн сан, ХТЭТ ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2022

⁷⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. 2017 он

⁷⁹ Мөн тэнд

Мөрдөн шалгах ажиллагааны хугацаа урт байх нэг үндэслэл нь гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэрэгт нотлох баримт цуглуулахтай холбоотой ажиллагаа юм. ЭХХШТХ-ийн 42.1 дүгээр зүйлд гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу хүсэлт илгээнэ гэжээ. Энэ нь манай улсаас эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан улсад хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд холбогдох нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх талаар хүсэлтээ илгээн шийдвэрлүүлэх эрх зүйн боломжийг бий болгосон зохицуулалт юм.

Ялангуяа хил дамнан үйлдэгдсэн гэмт хэрэгт гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын гэрээ байгуулсан байх шаардлага үүсдэг.

Монгол Улс одоогийн байдлаар нийт 17 улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан бөгөөд үүнийг судлаачдын зүгээс чамлалттай гэж үзэж байна. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримтыг тухайн улсаас цуглуулж бэхжүүлэхэд хүндрэл учрах, цаашлаад тийм боломжгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Тайлангийн өмнөх бүлэгт авч үзсэнээр Монгол Улсаас Зүүн болон Зүүн өмнөд Азийн улс орнууд руу охид, эмэгтэйчүүдийг худалдаалах чиглэл хэдий нь бий болсон нь албаны болон бусад эх сурвалжийн мэдээллээр баталгаажсан. Иймд ХХГХ үйлдэгдэж буй урсгал чиглэлтэй холбоотойгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улс, тухайлбал Норвег, Швед, Бельги, Камбож, Герман, Хонгконг, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг улс оронтой Монгол Улс харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн нэг ололттой тал нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг хэрэглэх⁸⁰ боломжтой болсон явдал юм. Гэвч ХХГХ-ийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц”, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, Хүүхдийн эрхийн конвенцын холбогдох заалтуудыг тус тус тухайлан дурдаж, шийдвэрлэсэн “ганцхан” тохиолдол байна⁸¹. Энэ нь аливаа гэмт хэргийг шүүхээр хэлэлцэхдээ нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын заалтыг баримтлах нөхцөл бүрдсэн гэж харж байгаа бөгөөд уг туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд шүүхийн байгууллага анхаарал хандуулж, идэвх, санаачилгатай ажиллах шаардлагатайг харуулж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хохирогч хамгаалал: ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасан байна.

Гэвч энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь эрхэлсэн тодорхой ажилгүйн улмаас төлбөрийн чадваргүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох явдал бага байна. Тухайлбал, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн

⁸⁰ Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална”

⁸¹ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 234 дугаартай шийтгэх тогтоол



шинжилгээ судалгааны хүрээнд ашигласан шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн дөрвөн хэрэгт хохирогчоор тогтоогдсон 10 иргэний найм нь огт өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгасан байна. Мөн хуулийн байгууллагад хандсан 20 хохирогчийн ес нь буюу 45% нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцсон бөгөөд бусад нь өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч байгаагүй гэсэн байна.

УИХ-аас 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргаснаас хойш төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг орхигдуулсныг үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд нөхөж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд мэргэшсэн өмгөөлөгч хөлсөлж байгаа нь бусад судалгааны тайлан⁸²-аас харагдаж байна.

Энэ байдлыг залруулах арга хэмжээг авч УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталснаар ХХГХ-ийн хохирогч, төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч чадах эрх зүйн орчин бүрджээ.

ЭХХШТХ-ийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг; хэрэв ийм хүн байхгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан.

Хэдийгээр төрөөс насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ өмгөөлөл, хууль зүйн туслалцаатай холбоотой асуудлыг орхигдуулсан ч хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах эрх зүйн орчныг бий болгосон байна. Гэвч хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд, ялангуяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагаас томилогдон оролцож байгаа төрийн албан хаагч нь үндсэн үүрэгт ажлын хажуугаар энэхүү үйл ажиллагаанд оролцдог тул мөрдөн шалгах ажиллагаанд тууштай, мэдлэг бүхий байдлаар анхаарч чадахгүй байна⁸³.

Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй байдаг.

Эрх зүйн орчны хувьд сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж болохоор байгаа боловч мөрдөн шалгах ажиллагааны явцад сэтгэл санааны хохирлыг тогтоох, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэхэд шаардлагатай нотлох баримт хангалтгүй цуглуулж байгаагаас хохирогч өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо бодитой тооцуулж чадахгүй, сэтгэл санааны хохирол учирсан гэж тооцсон ч түүний зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх ажиллагаа хийгддэггүй нь тодорхой харагдаж байна.

Хохирогч нар өмгөөлөгчтэйгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тохиолдолд л сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж байгаа бөгөөд сэтгэл санаанд ямар хэмжээний хохирол учирсныг зөвхөн өөрийн дотоод үзэмжээр тайлбарлаж, мөнгөн дүнг илэрхийлдэг. Гэвч өөрт учирсан сэтгэл санааны хохирлыг үндэслэлтэйгээр нэхэмжлэх, түүнийг нотлох байдал хангалтгүй байх тул шүүхээс сэтгэл санааны хохирлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхийг нь зааж шийдвэрлэж байна гэжээ.

⁸² ОУШХБ, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа, УБ.,2017

⁸³ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021

Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар ЭХХШТХ-аар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлж байгаа. Гэсэн хэдий ч манай улсад сэтгэл санааны хохирлыг тооцох хэмжүүр байхгүйгээс сэтгэл санааны хохирол учирсан гэдгийг тэр бүр тогтоох буюу сэтгэл санааны хохирол учирсан эсэхийг тогтоох нотлох баримт цуглуулдаггүй байна⁸⁴.

ХХГХ-ийн зарим хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрхтэй гэдгээ мэдэхгүй байгаа нь мөрдөгчөөс ЭХХШТХ-д заасан хохирогчоор тогтоосон тогтоолыг танилцуулахдаа түүний эрх, үүргийг тайлбарлаж өгөх явдал хангалтгүй байгаа, түүнчлэн өмгөөлөгчгүй байхтай холбоотой гэж үзэв.

Иргэний хуульд гагцхүү хуульд заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр⁸⁵, хохирогч "...гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах..."⁸⁶ эрхтэй гэж тус тус зааснаар хохирогчийн нэхэмжилж буй хохирлыг шүүх хянан шийдвэрлэх үүрэгтэй.

Хохирогчийн хохирлоо гаргуулна гэсэн шаардлага бүхий иргэний нэхэмжлэлийг шүүх үндэслэл, хохирол хор уршгийн хэр хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан шийдвэрлэдэг⁸⁷ тул нотлох баримтгүй нэхэмжилж буй хохирлыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар нэхэмжлэлээ гаргах эрхтэй болохыг нь зааж шийдвэрлэж байна. Судалгаанд оролцсон бүх шүүгч нар хохирогчийн сэтгэл санааны болон бие эрхтний хохирлоо нотлох баримтаа бүрдүүлэн иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх эрхийг нь нээлттэй үлдээдэг.

Мөн гэм хорын нэхэмжлэлийг хангуулах зорилгоор иргэний хариуцагчаар хуулийн этгээд, иргэнийг татаж шүүх хуралдаанд оролцуулах, гэм буруугийн хуралдаанаар хохирогчид үйлчилгээ үзүүлсэн этгээд /өмгөөлөгчийн хөлс, байрлуулсны зардал, сэтгэл зүйчийн хөлс/-ийн нэхэмжлэлийг гэм буруутай этгээдээс гаргуулж байгаа практик шүүхэд тогтсон байна.

2.4. Хамтын ажиллагаа

Хүн худалдаалахтай тэмцэх тухай (2012), Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ (2019) хуулиудад гэмт хэрэг тэр дундаа ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагуудын эрх үүргийг заасан нь салбар дундын зохицуулалтыг хийх эрх зүйн орчныг бүрдүүлсэн гол баримт бичгүүд байна.

Оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр Үндэсний хөтөлбөрт бие даасан зорилт тусгагдсан. Үндэсний хөтөлбөрийн 4-р зорилт болох "ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон ТББ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх" чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлт 93.3% буюу тодорхой үр дүнтэй гэж үнэлэгдсэн⁸⁸. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд гурван үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд Монгол Улсын иргэд ихээр зорчдог,

⁸⁴ Азийн сан, ХТЭТ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, 2022.,УБ

⁸⁵ Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэг. 2002 он

⁸⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дүгээр заалт. 2017 он.

⁸⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. 2017 он.

⁸⁸ ГХУСАЗЗ, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 54 хуудас.



ХХГХ-ийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай хамтран ажиллах, тогтмол мэдээлэл солилцох сувгийг бий болгох, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь бусад хоёр үйл ажиллагаанаас 20% доогуур буюу 80%-тай үнэлэгдсэн. Хөтөлбөрийн үнэлгээний тайланд дурдсанаар хамтын ажиллагааг хангах чиглэлд холбогдох байгууллагуудын зүгээс тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Ижил төстэй хийгдсэн судалгааны тайлангуудад дурдагдсанаар төрийн байгууллага, ОУБ, ТББ нь урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд хоорондоо хамтарч ажиллах байдал харьцангуй сайн гэж дүгнэсэн бол эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хохирогч байж болзошгүй хүмүүсийг эрт илрүүлэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлд хамтын ажиллагаа сул, хангалтгүй байна⁸⁹.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны өнөөгийн байдал, хүндрэл бэрхшээлийг дараах дэд бүлгүүдэд авч үзлээ.

2.4.1. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Монгол Улсын Засгийн газраас ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд салбар дундын уялдаа холбоог сайжруулах зорилгоор хэд хэдэн бүтэц, зохион байгуулалтыг бий болгон ажиллаж байна. Үүнд:

Зураг 15. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг хангах бүтцүүд

ГХУСАЗЗ-ийн дэргэдэх Дэд зөвлөл	Дэд зөвлөлийн дор байгуулагдсан Салбар дундын хамтарсан баг	ЕБС-ийн Хүүхэд хамгааллын баг
БШУЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, ХНХЯ, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар, ГХЯ, ГИХГ ХХЕГ, ТЕГ, ЦЕГ, ТББ-ууд	ГХУСАЗЗАА, УЕПГ, ГХЯ, ХНХЯ, ЭМЯ, ТЕГ, Эрүүгийн цагдаагийн алба, мөрдөн байцаах алба, ЦЕГ, ХХЕГ, Шүүх шинжилгээний ерөнхий газар, ГИХГ, ГБХЗХГ, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ	Сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, эмч, багш нар

Дэд зөвлөл: Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгасан. Үүнээс гол онцлог зохицуулалт нь Монгол улсад Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл ажиллахаар зохицуулж, дэд зөвлөлийн хэрэгжүүлэх эрх хэмжээг зааж өгсөн явдал юм.

⁸⁹ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, Улаанбаатар, 2021. 50-51 хуудас

Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг ГХУСА33-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар шинэчлэн баталсан. ГХУСА33-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар Дэд зөвлөлийн ажиллах нийтлэг журмын дагуу дэд зөвлөл нь нэг жилд 2-оос доошгүй удаа хуралдаж, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар сонсож, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааны талаар хэлэлцдэг⁹⁰. Монгол Улсад ХХГХ-тэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд албаны хүмүүс, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх тал дээр ахиц дэвшил гарч байна. Хэдийгээр байгууллагууд хамтран ажиллах хүсэл, санаачилгатай, хамтран төлөвлөгөө гаргадаг ч бодит байдалд төлөвлөгөөний дагуу ажиллах тал дээр төрийн байгууллагууд сул, мэдээллээ солилцох, харилцан уялдаатай ажиллах байдал хангалтгүй байгааг оролцогч талууд онцолсон⁹¹.

Салбар дундын хамтарсан баг: АНУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг (Салбар дундын хамтарсан баг)-ийг ГХУСА33-ны даргын 2021 оны 07 дугаар сарын 07 өдрийн А/17 тушаалаар байгуулан ажлын хэсгийн (цаашид Хамтарсан баг гэнэ) ажиллах удирдамжийг баталсан. Хамтарсан багийн бүрэлдэхүүнд Зураг 15-д харуулсан бүрэлдэхүүн багтаж байна.

“Салбар дундын хамтарсан баг” нь ХХГХ-т хариу арга хэмжээ авах, гэрч хохирогчийг хамгаалах, цогц үйлчилгээ үзүүлэх, чадавх бэхжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, статистик, мэдээлэл дээр үндэслэсэн шийдвэр гаргалтыг сайжруулах зэрэг чиглэлүүдэд хамтран ажиллана⁹². Тайлант хугацаанд буюу 2021 оны 9-р сарын 10-11 өдрүүдэд хамтарсан багийн гишүүдийн ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэгийг бэхжүүлэх, багийн стратеги төлөвлөгөөг хэлэлцэх анхдугаар хуралдаан зохион байгуулсан. Зарим төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын төлөөлөл “Салбар дундын хамтарсан баг”-т орсон ч гишүүд үндсэн ажлын хажуугаар хамтарсан багийн уулзалт, үйл ажиллагаанд бүрэн дүүрэн хамрагдаж чадахгүй асуудал гардаг талаар дурдсан. Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл салбар дундын хамтарсан багийг зөвхөн төслийн хүрээнд түр хугацаанд ажиллах нэгж болгохгүйн тулд хуульчлах шаардлагатайг сануулсаар байна. Мөн 2022 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд салбар дундын хамтарсан багийг хууль ёсны бүрэн эрхтэй болгон тогтвортой үйл ажиллагааг ханган, шаардлагатай хөрөнгө санхүүжилт олгох бодлогыг хэрэгжүүлэх талаар зөвлөмжийг Монгол улсад өгсөн байна. Эндээс үзэхэд хамтарсан багийг илүү тогтвортой ажиллуулахын тулд хуульчлах хэрэгцээ шаардлагатай нь харагдаж байна.

ЕБС-ийн Хүүхэд хамгааллын баг: БШУЯ-ны сайдын 2019 оны А/476 дугаар тоот тушаалаар ЕБС-ийн орчин дахь “Хүүхэд хамгааллын бодлого” батлагдан гарсан. Үүнтэй холбоотой 2019 оноос сургуулиудад сургуулийн захирлаар ахлуулсан сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, эмч, багш нараас бүрдсэн “Хүүхэд хамгааллын баг”-ийг байгуулан хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажил хийгдэж байна. Ингэснээр хүүхдийн эрхийг хангах, эцэг эх, асран хамгаалагчдад нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хүүхдийг хүчирхийлэл, дарамт мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг үзүүлэх, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээг үзүүлэх боломж нэмэгдсэн. Охидыг

⁹⁰ ГХУСА33, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022. 54 хуудас.

⁹¹ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, Улаанбаатар, 2021. 52 хуудас.

⁹² ГХУСА33-ны даргын 2021 оны 07 дугаар сарын 07 өдрийн А/17 тушаал, Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай. Улаанбаатар. 2021.




хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь суурь судалгааны үр дүнгээр хүүхэд хамгааллын бодлого, үүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ тусгагдаагүй байв. ЕБС-уудад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн сургуулийн нийгмийн ажилтны ажил үүрэг гэж үзэх нь нийтлэг, багш нарын ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэг бага тул энэ чиглэлээрх үүргээ төдийлөн ухамсарлахгүй, сэтгэл зүйчийн цалин хөлсийг ОУБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр шийдэж ажиллуулж байгаа нь анхаарал татаж байна. Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн мэдээлэл алдагдсантай холбоотой хүүхэд өөр сургууль руу шилжих үзэгдэл өнөөг хэр нь гарсаар байна⁹³.

Төрийн байгууллагуудын дата, мэдээлэл солилцоо: ХХГХ-тэй тэмцэх чиглэлд төрийн байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл солилцох байдал хангалтгүй, байгууллагуудын тоон мэдээлэл зөрүүтэй зэрэг асуудлыг оролцогч талууд тайлангуудад нийтлэг онцолж байсан.

Гэмт хэргийн бүртгэл, мэдээллийн урсгалын өнөөгийн дүр зургийг харвал цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд улирал, хагас, бүтэн жилээр гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг ҮСХ-ны Нийгмийн статистикийн газарт нэгтгэн хүргүүлж улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын мэдээлэлд тусч, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшин, олон нийт, ТББ, ОУБ-уудад хүрдэг байна. Зураг 18-д харуулсан зураглалд ХХГХ-тэй холбоотой мэдээллүүд багтаж байна.⁹⁴

Зураг 16. ХХГХ-ийн бүртгэл, мэдээллийн урсгал



Эх сурвалж: ХХГХ-тэй тэмцэхэд шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, ашиглах, өнөөгийн тогтолцоо, түүнийг сайжруулах боломж, судалгааны тайлан, Азийн сан, 2022

⁹³ ИИС, ИРИМ, Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь төслийн суурь судалгааны тайлан, Улаанбаатар. 2022, 46 хуудас

⁹⁴ Азийн сан, ХХГХ-тэй тэмцэхэд шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, ашиглах, өнөөгийн тогтолцоо, түүнийг сайжруулах боломж, судалгааны тайлан, 2022

Монгол Улсад ХХГХ-ийн талаарх төрөлжсөн мэдээллийн сан байхгүй хэдий ч ГХУСА33 нь Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ГХУСА33 Монголын криминологичдын холбоотой хамтран эрхлэн гаргадаг “Гэмт хэргийн цагаан ном”-д ХХГХ-ийн гаралт, төлөв байдал, шалтгаан нөхцөлийг судлан оруулж, олон нийтийн хүртээл болгосон.⁹⁵ Хууль сахиулах байгууллагууд, шүүхийн байгууллага нь ХХГХ-тэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагуудад бэлтгэн хүргүүлж байна

Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын Эрүүгийн цагдаагийн алба нь дотоод бүртгэлийн цахим сантай бөгөөд уг сан нь ХХГХ-ийн холбогдогч талуудын бүхий л мэдээллийг бүртгэдэг байна⁹⁶. Товчилсон тайлан мэдээг харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад нэгдсэн сүлжээгээр хүргүүлэхийн зэрэгцээ хэвлэмлээр ҮАБЗ, ХЗДХЯ, УЕПГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулдаг байна. ХХГХ-ийн дэлгэрэнгүй тоон мэдээлэл, судалгааг зөвхөн байгууллага, албан тушаалтны чиглэл хүсэлтийн дагуу гаргадаг. ЦЕГ-ын даргын 2020 оны А/128 дугаар тушаалаар баталсан жагсаалтын дагуу 36 байгууллага, албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг хүргүүлдэг байна⁹⁷.

Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ) нь “Прокурорын байгууллагын мэдээлэл, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж байна. ХЗДХЯ-ны дэргэд байгуулагдсан “Цахим нэгтгэл” төслийн баг нь УЕПГ дээр төвлөрөн ажиллаж, нэгдсэн санг үүсгэсэн байна⁹⁸. УЕПГ нь Монгол Улсын ерөнхийлөгч, УИХ, ЗГ, ГХУСА33-д Эрүүгийн болон зөрчлийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэн хүргүүлдэг байна.

Шүүхийн байгууллагын тухайд ШЕЗ-ийн 2018 оны 20 дугаар тогтоолоор “Шүүхийн статистик мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу бүх шатны шүүхээс маягтуудын дагуу эксел файлаар тогтоосон хугацаанд жилд дөрвөн удаа ирүүлж, нэгтгэгдэн улсын хэмжээний мэдээллийг гаргадаг байна.

Шүүхийн байгууллага тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэргийн тоон мэдээлэл цагдаагийн байгууллага болон прокурорын байгууллагын тухайн жилд хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан, хяналт тавьсан хэргийн тоотой тулгах, харьцуулах боломжгүй байдал үүсдэг. Шүүх тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэргийг хянан шийдвэрлэж, давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж өмнөх шатны шүүхийн шийдвэр өөрчлөгдсөн хүчингүй болсон тохиолдолд тухайн хэргийг дахин шийдвэрлэх явцад зөрүү гардаг⁹⁹. Тайланг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, ХЗДХЯ-д жилийн болон улирал тутмын тайланг файлаар болон хэвлэмлээр, түүнчлэн байгууллага, иргэд, судлаачдын ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа, мэдээллийг гарган хүргүүлдэг байна. Шүүхийн байгууллага цахим мэдээллийн систем байхгүй, гэхдээ хууль сахиулах байгууллагуудын хоорондын дундын мэдээллийн санд холбогдсон байдалтай байна.

⁹⁵ ГХУСА33, Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, ашиглах, өнөөгийн тогтолцоо, түүнийг сайжруулах боломж, Улаанбаатар, 2022, 6 ба 13 хуудас.

⁹⁶ ГХУСА33, Эс Ай Си Эй, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2022, 27 хуудас.

⁹⁷ ГХУСА33, Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, ашиглах, өнөөгийн тогтолцоо, түүнийг сайжруулах боломж, Улаанбаатар, 2022, 23 хуудас

⁹⁸ Мөн тэнд, 32 хуудас.

⁹⁹ Мөн тэнд, 31 хуудас.



Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам (ХНХЯ)-аас www.E-tuslamj.mn платформ, Нийгмийн ажлын мэдээллийн сан /НАМС/ програмын хөгжүүлэлтийг хийсэн. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлагын бүртгэлийн програмын гуравдугаар шатны хөгжүүлэлт 2021 онд бүрэн хийгдэж, утас, мессеж, чатаар дуудлага, мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх боломжийг өргөжүүлсэн. ГБХЗХГ-аас 2017 оноос Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн санг хөгжүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 2017 онд Хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэлийн дэд цэс, 2018 онд Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвөөр үйлчлүүлж байгаа хүүхдийн бүртгэлийн дэд цэс, "Эрсдэлийн программын бүртгэл" дэд цэсийг тус тус үүсгэн мэдээллийн санг бүрдүүлж байна. Гэвч ЦЕГ-аас Эрсдэлийн программын бүртгэлтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг гаргадаггүй бөгөөд ХХГХ-тэй холбоотой мэдээллийг хуулийн дагуу ЦЕГ-аас авдаг.

Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ) нь зөвхөн гадаадын иргэний нэгдсэн мэдээллийн санд виз, зөвшөөрөл олгохтой холбогдсон мэдээллийг бүртгэдэг байна. ЦЕГ-тай Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн хохирогч, хэрэгтэн болсон гадаадын иргэдийн визний талаарх мэдээллийг харилцан хуваалцах байдлаар ажилладаг.

Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) нь "Хилийн орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн мэдээлэл"-д ХХГХ-тэй холбоотой байж болзошгүй тохиолдлыг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ) нь ХХГХ-тэй холбоотой мэдээлэл байдаггүй, "Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн систем"-д бүртгэгдсэн мэдээллийг нэгтгэн ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ, ГИХГ хүргүүлж байна.

Хэдийгээр цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн давхардлыг арилгах, харилцан мэдээлэл дамжуулах сүлжээ, програм хангамжийн орчинг бүрдүүлэх чиглэлд тодорхой ажил хийгдэж байгаа ч мэдээллийн зөрүүтэй байдал гарсаар байгааг цаашид анхаарах шаардлагатай.

2.4.2. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр ТББ-тай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжих, туслах, Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг хариуцуулахаар, мөн ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр гадаад улс, ОУБ-тай хамтран ажиллахаар тус тус заасан.

Түүнчлэн, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ТББ-ийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шинэ арга барил, ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн талаар санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллахаар тусгасан. Монгол Улс эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг 17 улстай хийсэн боловч өнөөдрийг хүртэл ХХГХ-ийг шийдвэрлэх чиглэлээр ашигласан туршлага цөөн байна¹⁰⁰. Энэ нь нэг талаас илэрч, мөрдөгдөж, шийдвэрлэж байгаа хэргийн тоо цөөн, нөгөө талаас хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч албан хаагчдын ойлголт мэдлэг, чадавх сул байгаатай холбоотой юм.

¹⁰⁰ ОУШХБ, IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, УБ., 2022. 68 хуудас.

Төрийн байгууллагууд нь ТББ болон ОУБ-уудтай хамтран албан хаагчид, олон нийт, оюутан сурагчдад зориулсан сургалтуудыг зохион байгуулах, судалгаа, үнэлгээ хийх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, техникийн зөвлөгөө, зөвлөн туслах, санхүүжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, үндэсний аян зохион байгуулахад хамтран ажилласан байна. Харин ОУБ болон ТББ хамтран ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, модуль боловсруулах ажлуудыг түлхүү хийсэн. Эндээс үзэхэд байгууллагууд гол төлөв урьдчилан сэргийлэх ажлуудад хамтран ажилласан байна.

Харин ХХГХ-тэй тэмцэх чиглэлд илрүүлэлт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хохирогч хамгааллын үйлчилгээний чиглэлээр хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай гэдэг нийтлэг дүр зураг харагдаж байна. Энэ чиглэлд талуудын хамтын ажиллагааг тоон утгаар үнэлүүлсэн судалгааны үр дүнгээр бүх талуудын хамтын ажиллагааг сайн гэж ОУБ-ын төлөөллийн 80%, төрийн байгууллагын төлөөллийн 68%, ТББ-ын төлөөллийн 64%-тай тус тус үнэлсэн байна¹⁰¹. Өөрөөр хэлбэл, хамтын ажиллагааны үр дүнтэй байдалд бүх талууд ялгаатай байр суурьтай байна.

Оролцогч талуудад хамтын ажиллагааны хүрээнд тулгардаг хүндрэл бэрхшээлийг авч үзвэл. Үүнд:

Хүснэгт 11. Хамтын ажиллагааны хүрээнд байгууллагуудад тулгарч буй бэрхшээл /матриц/

Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Олон улсын байгууллага
Хүний нөөцийн тогтвор суурьшилтай бус байдал нь хэрэг илрүүлэлт, хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх талтай;	Хууль тогтоомжийн нэгдсэн ойлголтод хүрээгүй;	ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлууд олон улсын төсөл, хөтөлбөрөөр хязгаарлагдан цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах тал дээр идэвх санаачилга, нөөц боломж хангалттай бус;
Шүүх эмнэлэг, цагдаагийн газар хамтран ажилладаг хэдий ч шийдвэр гаргалт хангалтгүй;	Хуулийг хэрэгжүүлэх тал дээр сул;	Хамтын ажиллагааны механизм бүрдээгүй;
Олон нийт ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг дутмаг, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байгааг мэдэхгүй зэргээс үзвэл нөлөөллийн ажил үр дүн багатай.	Хохирогчийг хамгаалах хуулийн зүйл заалтууд хэрэгжихгүй;	Тогтвортой бүтэц байхгүй, хүний нөөцийн тогтворгүй.
	Нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүй;	
	ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд хүний нөөц, техник технологи хангалтгүй.	

Хамтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг арилгах, цаашид үр дүнтэй ажиллахад төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, кейстэй ажиллах механизм, тогтолцоо, зохион байгуулалтыг системтэй болгох, талуудын оролцоо, чиг үүрэг тодорхой байх, мэдээллийг тогтмол солилцох, жил бүр хамтын ажиллагааны үр дүнг тодорхойлох, хүлээлтээ нэгтгэх, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдэхэд анхаарах шаардлагатай байна.

¹⁰¹ ДЗМОУБ, IRIM, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021, 53-54 хуудас.



ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд, ОУБ, ТББ хамтран хэрэгжүүлж байна. 2017-2021 онд үйлчилсэн Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн эцсийн үнэлгээгээр ерөнхий үнэлгээ 90.76%-тай бөгөөд Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах ажил 93.9%, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах ажил 81.25%, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх ажил 93.3%-ийн биелэлттэй байна гэжээ. Гэсэн хэдий ч ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай төсвийн 20 гаруй хувийг COVID-19 цар тахлын хариу арга хэмжээнд шилжүүлсэн зарцуулсантай холбоотой зарим үйл ажиллагаанууд хэрэгжээгүй, байгууллага хоорондын уялдаа, зохицуулалт сул байна.
- Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гол төлөв хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, гадаад улс орнуудын ижил төстэй байгууллагуудаас туршлага солилцох, судалгаа, үнэлгээний ажил хийх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголт, хандлагад нөлөөлөхүйц үндэсний аян, сурталчилгаа, мэдээллийн хуудас, брошюр, нэвтрүүлэг, баримтат кино, анимэйшн, контент, гарын авлагыг бэлтгэх ажлуудыг ОУБ-уудын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр төрийн болон ТББ дангаараа, эсвэл байгууллагууд хамтран хийсэн.
- ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ОУБ, ТББ-ын үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлсэн ажлуудыг давтан хэрэгжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах байдал хийгдэхгүй байна.
- Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудад ХХГХ-ийн хохирогчийг таньж илрүүлэх албан ёсоор батлагдсан асуумж, загвар, зааварчилга байхгүй тул ГИХГ, МХЕГ, ХХЕГ зэрэг байгууллагын албан хаагчид өөрийн итгэл үнэмшил, туршлагад тулгуурлан нэмэлт асуулт асуух, ажиглах байдлаар илрүүлэхийг зорьж байна.
- ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн байгууллагуудын оролцоо харилцан адилгүй, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд оролцоо хангалтгүй байгаа нь холбогдох салбарын журам, зохицуулалтын баримт бичигт тусгалаа бүрэн олоогүй, хэзээ уялдуулах нь бүрхэг, тодорхойгүй байгаатай холбоотой байна.
- Сүүлийн жилүүдэд Монгол улсад насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, хүүхдийг цахим бэлгийн мөлжлөгөөр ашиглах арга замаар ХХГХ-ийн хохирогч болох асуудал гарч байгаа бөгөөд энэ чиглэлд хийгдсэн урьдчилан сэргийлэх ажлуудын талаар мэдээлэл байхгүй байна.

Хохирогч хамгааллын чиглэлээр:

- Манай улсад ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, шаардлагатай туслалцаа дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чадавх илүү ТББ-ын чадавх дээр суурилсан байна. Төрийн байгууллагын дэргэдэх түр хамгаалах байр нь ХХГХ-ийн гэхээсээ илүүтэй гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарт шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 тушаалаар Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх зааврыг баталсан. Гэвч энэхүү заавар нь зөвхөн төрийн захиргаа, төрийн үйлчилгээний гүйцэтгэх, туслах албан тушаалд ажиллаж буй албан хаагч болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүд ашиглаж болохоор батлагдсан байна. Цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар ХХГХ-ийн хохирогчийг таньж илрүүлэх, тогтоох нэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжийг боловсруулах, батлуулах шаардлагатай байна.
- ХХГХ-ийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа байхгүй байна. Өнөөг хүртэл төрийн болон ТББ-ын зүгээс хохирогчдод үзүүлсэн туслалцааны талаарх тоо мэдээ зөрүүтэй байгаа бөгөөд ТББ-ууд илүү олон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ, туслалцаа үзүүлсэн байна.
- ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнд хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг тусгайлан зохицуулах хэрэгцээ үүссэн нь “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандарт”-ыг нэн яаралтай батлах шаардлагатайг харуулж байна.
- ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын нийтлэг стандартаар ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний орчин, чанарыг тогтоосон боловч энэ стандарт нь зөвхөн төрийн бус байгууллагад хамааралтай байна. Харин төрийн байгууллагын дэргэдэх хамгаалах байр, түүний үйлчилгээ, чанар хүртээмж ямар ч стандартаар зохицуулагдаагүй байгааг анхааралдаа авах шаардлагатай байна.
- ХХГХ-ийн хохирогч, хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал нь хүүхдэд ээлтэй бус байна. ХХГХ-ийн улмаас бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, хохирогч хамгааллын тогтолцоо хангалтгүй байна.
- ХХГХ-ийн хохирогч хүүхдэд шаардлагатай, дэмжлэг туслалцаанд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөл тусгай бие даасан хүүхдийн төрөлжсөн хамгаалах байрыг санал болгохын зэрэгцээ урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ үүссэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно гэж заасан. Хэргийн төрлөөр дагнасан шүүх байгуулагдаагүй учир эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдэд ХХГХ, түүний хохирогч нарын мэдүүлгийг ямар байдлаар үнэлэх, ялангуяа олон улсын практикт энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарт явуулах шүүн таслах ажиллагаанд юуг анхаардаг, насанд хүрээгүй хохирогч нарыг хэрхэн хамгаалдаг зэрэг хохирогч хамгааллын үйл ажиллагааг шүүхээс хэрхэн явуулдаг, ял шийтгэлийг оногдуулахдаа юуг голчлон харгалзан үздэг



зэрэг сургалтыг давтан, хэрэгцээг нь хангасан байдлаар зохион байгуулах замаар энэ төрлийн гэмт хэргийн онцлог ойлголт, мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх, ойлголтын зөрүүг арилгах явдал чухалд тооцогдож байна.

- Эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож, өрсөлдөх хэм хэмжээг бий болгосон, оногдуулах ялыг ХХГХ-т оногдуулах ялаас бага байхаар хуульчилсан нь хууль хэрэглээний практикт эргэлзээтэй, хүндрэлтэй байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл ХХГХ-ийн субъектив талын шинжийг тогтоож чадаагүй бол өөр гэмт хэрэгт тооцож, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөнгөн ял оногдуулах боломж бүрджээ.
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын заалтыг ашиглах үзэгдэл шүүхийн практикт нэвтэрч эхэлсэн нь ажиглагдаж байна. Гэвч бусад баримт бичгүүд, тухайлбал эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг ашиглан хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой тогтоох эрх зүйн боломж бүрдсэн байхад түүнийг ашиглан гадаад улсад нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа явуулах байдал хангалтгүй байна.
- Цар тахлын үе дэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, улсын гадаад урсгал чиглэл болон дотоод дахь хөдөлгөөний хязгаарлалт нь ХХГХ-ийн гаралтыг буурахад нөлөө үзүүлсэн мэт харагдаж байгаа ч цахим орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх, хүүхдийг мөлжлөгт өртүүлэх явдал өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.
- Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэгт хууль ёсны төлөөлөгчөөр оролцож буй төрийн байгууллагын албан хаагч нь ЭХХША-нд нэр төдий оролцох явдал түгээмэл бөгөөд хохирогч хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар дорвитой ажиллахгүй байна.
- Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд хохирогчид учирсан хохирлыг дан ганц бие махбодод учирсан гэмтлийг зэргээр биш хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол гэж тодорхойлон зааж өгсөн. Гэсэн хэдий ч ХХГХ-ийн хохирогчид учирсан сэтгэл зүйн гэмтэл (учирсан хохирол)-ийг тооцох аргачлал, зохицуулалт байхгүй байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйн гэмтлийг тогтооход хүндрэлтэй байна.
- УИХ-аас Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан нь төлбөрийн чадваргүй хохирогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлоо хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд хамгийн чухал алхам болжээ.
- ХХГХ-ийг шалгаж шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний тогтворгүй байдал нь хэрэг илрүүлэлт, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хамтын ажиллагааны чиглэлээр:

- ХХГХ-тэй тэмцэхэд салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бий болгон ажиллаж байгаа нь Монгол Улсын Засгийн Газар, холбогдох байгууллага ихээхэн хүчин чармайлт гаргаж буйг илтгэнэ.
- Үндэсний хөтөлбөрийн “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон ТББ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтын биелэлт 83.3% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” хэдий ч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа тул хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

- Төрийн болон ТББ, ОУБ нь урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд хоорондоо хамтарч ажиллах байдал харьцангуй сайн гэж үнэлсэн бол эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хохирогч байж болзошгүй хүмүүсийг эрт илрүүлэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлд хамтын ажиллагаа сул, хангалтгүй байна.
- ХХГХ-ийн талаарх төрөлжсөн мэдээллийн сан байхгүй, байгууллага хоорондын ил тод, мэдээлэл солилцоо хангалтгүй буюу хаана ямар байгууллага ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн, төрөөс тухайн чиглэлд ямар бодлого барьж ажиллаж байгаа талаар тогтолцооны оролцогч талуудын мэдлэг, мэдээлэл дутмаг, нэгдсэн ойлголтгүй байна.
- Монгол Улс эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг 17 улстай хийсэн боловч өнөөдрийг хүртэл ХХГХ-ийг шийдвэрлэх чиглэлээр ашигласан туршлага цөөн байна.

Монгол Улс дахь хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлангийн хүрээнд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдаж буй төсвийг нэмэгдүүлэх, энэ төрлийн аливаа үйл ажиллагааг олон улсын санхүүжилтийг татах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах;
- ОУБ, ТББ-ын ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр амжилттай хэрэгжсэн ажлуудыг хүний нас, хүйс, бэлгийн чиг баримжаа (ЛГБТ), нийгмийн ялгаатай бүлгүүд (хөгжлийн бэрхшээлтэй иргэд), амьдран суугаа газрын онцлогт тохируулан хүргэх, давтамж, цаг хүрээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын төлөвлөгөөтэй уялдуулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаа, прокурор, шүүх, хилийн шалган нэвтрүүлэх алба, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр кейсэд болон асуудалд суурилсан үр дүнтэй сургалтуудыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай эсвэл мэргэшсэн эрдэмтэн судлаачдын багтай хамтран холбогдох төрийн байгууллага зохион байгуулах;
- ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийг холбогдох салбарын журам, зохицуулалтын баримт бичигтэй уялдуулах ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тусган, хэрэгжүүлэх, хяналтыг тавих; Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөт нэвтрэх заалтыг хэрэгжүүлэхийн тулд бусад хууль тогтоомжийг уялдуулах;
- Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд байгуулагдсан ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий салбар дундын хамтарсан багт оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, үйл ажиллагааг нь цаашид тогтвортой үргэлжлүүлж, шаардлагатай санхүүжилтийг бий болгох зорилгоор салбар дундын хамтарсан багийн ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- ГХУСА33-өөс ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон ТББ-ын албан хаагч, мэргэжилтнүүдэд зориулж, ХХГХ-ийн хохирогчийг таньж илрүүлэх удирдамжийн бичиг баримтыг батлан гаргаж, хэрэгжилтийг хангах;



- Төрийн байгууллагуудын ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Засгийн газар улсын төсөвт тусган, хэрэгжүүлэх, хяналтыг тавих;
- Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөт нэвтрэх заалтыг хэрэгжүүлэхийн тулд бусад хууль тогтоомжийг уялдуулах ажлыг салбарын эрх бүхий хүмүүс цаг алдалгүйгээр хариуцан хийх;
- Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарыг сургалтад хамруулах, хүний нөөц болон санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэнэтийн шалгалт хийх эрхтэй болгох замаар ААНБ-уудад хийх шалгалтыг сайжруулах, хөдөлмөрийн мөлжлөгийн шалгуур үзүүлэлтээр таньж, илрүүлэх, үнэлгээ өгөх;
- Насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, секс аяллыг зохион байгуулах, хүүхдийг цахим бэлгийн мөлжлөгөөр ашиглах асуудлыг гүнзгийрүүлэн судлах, дүн шинжилгээнд суурилсан урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох төрийн байгууллагууд (ХЗДХЯ, ХНХЯ, ЦЕГ ба бусад), ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран зохион байгуулах, үр дүнг танилцуулах;
- ХХГХ-ийн хохирогчид нь уг гэмт хэргийн элсүүлэх үйл явцад оролцож байгаатай холбоотой тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хорт зуршлаас (архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл) сэргийлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход чиглэгдсэн олон талт сургалт, хөтөлбөрийг төрийн болон ТББ-ууд санаачлан хэрэгжүүлэх, холбогдох зардлыг шийдэх;

Хохирогч хамгааллын чиглэлээр:

- ГБХЗХГ-аас холбогдох байгууллагатай хамтран ХХГХ-т өртөж хохирсон хүүхэд болон тусгай хэрэгцээт хүнийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх стандартыг баталж, хэрэгжүүлэх. Ингэснээр хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг журамлах боломжтой болно.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хохирогч хамгааллын үйлчилгээнд хамруулах зохицуулалтыг тусгах;
- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг боловсруулах, хүүхдэд урт хугацаанд цогц үйлчилгээ үзүүлэх механизм бий болгох, хэрэгжүүлэх;
- Хохирогч хамгааллын үйлчилгээнд зориулсан санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгах, батлуулах;

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:

- ХЗДХЯ болон ГХЯ хамтран өмнө нь байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх;
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /ХХГХ хамаарна/ ихээр үйлдэгдэж буй Малайз, Норвег, Швед, Арабын Нэгдсэн Эмират, Камбож, Япон, Филиппин, АНУ зэрэг гадаадын улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг яаралтай байгуулах;

- Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг 12.3.2, 12.3.3 дахь хэсэг, 13.13 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйлд заасан Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.4 дүгээр зүйлд заасан Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар зүйлд заасан Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд заасан Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйлд заасан Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйлд заасан Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хүчингүй болгож энэ төрлийн гэмт хэргийг мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх;
- Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хэрэгжиж байгаатай уялдуулан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд 1 дэх заалтад “цус, эс” ... гэж нэмэх;
- Цагдаагийн болон прокурорын байгууллагын бүтцэд бий болсон хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бэхжүүлэх, орон нутагт ажиллах орон тоо, бүтцийн асуудлыг шийдвэрлэх¹⁰²;
- Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж байх;
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талууд нь хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө гэж заасан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Сэтгэл санааны хохирол тооцох” аргачлалыг яаралтай боловсруулж, практикт нэвтрүүлэх;
- Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурор яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн гурван хэрэг тутмын нэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаад анхаарч, цаашид хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, шүүхэд хуулийн хамгийн боломжит богино хугацаа зарцуулж, хэргийг шийдвэрлэж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Хамтын ажиллагааны чиглэлээр:

- ХХГХ-ийн чиглэлээр бэлтгэгдсэн, чадавхжуулсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажилуулахад төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлогоо чиглүүлэх;
- Салбар дундын хамтарсан багийн тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс хуульчлах;

¹⁰² Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн алба хаагчдын хүний нөөц, орон тоо хангалтгүй, алба хаагчдын шилжилт хөдөлгөөн байнга явагддагтай холбоотой хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чадавх суларч илрүүлэлт буурдаг.

Жишээлбэл: Тус тасаг 2021 онд нийт 5 алба хаагч ажиллахаас 2 алба хаагч шилжиж, шинээр 2 алба хаагч томилогдсон, шинээр томилогдсон алба хаагчдыг сурган дадлагажуулах хугацаа шаарддаг. Энэ онд 2 алба хаагч томилогдон ажиллаж байгаад 1 алба хаагч өөр албанд шилжин томилогдсон. Цаашид алба хаагч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.



- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хохирогч байж болзошгүй хүмүүсийг эрт илрүүлэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлд төрийн байгууллагууд нь ОУБ-тай Техникийн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, санхүүжүүлэхэд, ТББ-тай хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах;
- ХХГХ-ийн талаар мэдээллийн санг бий болгох ажлыг эрчимжүүлэх, тогтвортой ажиллуулах төлөвлөгөөг гаргах, холбогдох зардлыг шийдэх, ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагууд өөр хоорондоо ил тод, мэдээлэл солилцох тал дээр нэгдсэн ойлголтод хүрэх;
- ХХГХ-тэй тэмцэх чиглэлд төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд албан хаагчийн, ялангуяа хүүхдийн эрхийн байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн, баг/хороо болон сургуулийн нийгмийн ажилтны ажил үүрэгт нь тодорхой тусгах, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх, цалин хөлс, урамшууллыг олгох, чадавх бэхжүүлэх болон мэргэжлийн дэмжлэг тусалцааг холбогдох байгууллагуудаас үзүүлэх;

Хавсралт 1. АШИГЛАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

Судалгааны тайлан:

1. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааны тайлан, Азийн сан, ХТЭТ ТББ, 2022
2. “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, ашиглах, өнөөгийн тогтолцоо, түүнийг сайжруулах боломж” судалгааны тайлан, Азийн сан, 2022
3. Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан, Азийн сан, ХТЭТ ТББ, 2022
4. Хүн худалдаалах гэмт хэргийн чиг хандлага, түүнтэй тэмцэхэд тулгарч буй асуудал, танилцуулга, ЭЦА, 2022
5. Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарвал зохих асуудал, танилцуулга, УЕПГ, 2022,
6. Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан, Азийн сан, ХТЭТ ТББ, УБ.,2022
7. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, SICA, 2022
8. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах үйлчилгээний үйл явцыг тодорхойлох нь судалгааны нэгдсэн тайлан, Г.Оюунболд, Улаанбаатар, 2022.
9. Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь суурь судалгаа, Хүүхдийг Ивээх сан, IRIM судалгааны хүрээлэн, Улаанбаатар, 2022
10. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд зохион байгуулагдсан “ХХГХ-ийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл хэлэлцүүлэг”-ээс гарсан мэдээ, мэдээлэл, 2022
11. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: “Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн суурь судалгаа, ДЗМОУБ, IRIM, 2021
12. “Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааны тайлан, ДЗМОУБ, 2021
13. Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгийн болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, ОУШХБ, IRIM, 2021
14. Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, Үнэлгээний тайлан, Корам Хүүхдийн хууль эрх зүйн төвийн дэргэдэх Корам Интернейшнл, ХНХЯ, 2021
15. Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх төслийн тайлан, ХТЭТ ТББ, 2020,
16. “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” тайлан, ХЗДХЯ, “Эс Ай Си Эй” ХХК 2019
17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа”, ОУШХБ, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, УБ.,2017



18. U.S Department 2022 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан
19. U.S Department 2022 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан
20. U.S Department 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан
21. U.S Department 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

Дата, статистик мэдээлэл:

22. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, 2022 оны 1 улиралын байдлаар, Монцамэ, Холбоос: Монгол Улсад 92 орны 5500 хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна (montsame.mn)
23. Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагаас авсан мэдээ
24. Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийн төв. Дуудлагын нэгдсэн тоон мэдээлэл, Улаанбаатар, 2021.

Эрх зүйн баримт бичгүүд:

25. Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаал. ХХГХ-ийн хохирогчийг таних, илрүүлэх заавар
26. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан "Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал"
27. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн төсөл
28. Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
29. ГХУСА33-ын даргын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн А/17 дугаар тушаал Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай
30. Хүн худалдаалахтай тэмцэх Салбар дундын хамтарсан багаас Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн хуралдаанаар танилцуулах санал, 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр, УБ

